

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-48

-
1. *Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/*
- 4-48

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 08 дугаар сарын 29-ний
өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут;

Тасалсан: Б.Түвшин.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Ж.Дэлгэрсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Санхүү, эдийн засгийн газрын дарга Ж.Бямбасүрэн, Монголбанкны дэд ерөнхийлөгч Д.Энхтайван, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Д.Нямжаргал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Оюунгэрэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Хяналт үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Буяннэмэх, Ерөнхий нягтлан бодогч Л.Оюунчимэг, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, мөн банкны Банкны бүтцийн өөрчлөлтийн бодлогын газрын захирал Н.Ариунбат, Капитал банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, мөн газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Алтанцэцэг, Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү,

хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, мөн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Т.Мөнгөнцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, мөн газрын Ерөнхий санхүүч Ц.Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагваа, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Ерөнхий нягтлан бодогч Ш.Цогзолмаа, Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Мөн Аж үйлдвэржилтийн бодлогын болон Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Төсвийн болон Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлт, Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, П.Ганзориг, Ж.Батжаргал, Б.Заяабал, Ж.Баясгалан, Дав.Цогтбаатар, Ж.Баярмаа, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны дэд ерөнхийлөгч Д.Энхтайван, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Эрүүл

мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Б.Заяабал нар үг хэлэв.

Д.Батбаяр: “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дэд хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, 12 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
16 цаг 32 минут

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Батбаяр: Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Дэд хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Батбаяр гишүүн ирсэн. Батжаргал гишүүн ирсэн байна. Батлут гишүүн албан ёсоор чөлөө авсан. Ренчиндоржийн Батболд гишүүн ирсэн байна. Булгантуяа гишүүн ирээгүй байна. Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирж байна гэсэн. Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна. Банзрагчийн Түвшин гишүүн ирж байна гэсэн. Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн ирцдээ орсон байна. Ингээд ирц хүрсэн учраас албан ёсоор хуралдаанаа эхэлье. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Өнөөдрийн манай дэд хорооны хуралд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд байгаа юу. Дараагийнх нь явж байж болдог юм уу. Үүний дараа Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тус тусад нь хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Тэгвэл Ерөнхий аудитор эхлээд танилцуулаад явчихъя.

Сангийн сайд эзгүй байгаа юм байна. Тэгэхээр оронд нь Сангийн сайдыг орлоод Монгол Улсын Сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Тулга хүрэлцэж ирсэн байна. Оронд нь төлөөлөөд илтгэлийг нь уншиж болох уу. Манай Тамгын газрынхан. Орлодог сайд юм байна. Тэгвэл Тулга сайдын микрофоныг нээе.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн та бүхэнд танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв төрийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Улсын болон орон нутгийн 62 төсвийн ерөнхийлөн захирагчийн 5442 төсөвт байгууллага,

619 төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, 370 төрийн сан, 295 төсөл сан, нийт 6726 байгууллагын тайланг нэгтгэсэн байна.

Боомтын сэргэлтээр 2022 оны сүүлийн хагаст бий болсон нүүрсний экспортын сэргэлтийг хадгалж, дэлхийн зах зээлд буурч байсан түүхий эдийн үнийн бууралтыг ил тод, нээлттэй, өрсөлдөөнт биржийн арилжаанд илжүүлсэн нь уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарыг эрчимжүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 68,9 их наяд төгрөг буюу төлөвлөгөөнөөс 14,4 хувиар давж, эдийн засгийн бодит өсөлт 7 хувь буюу төлөвлөснөөс нэг пунктээр өслөө.

Монгол Улс 2023 онд 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 24,4 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 15 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 5,9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт өмнөх оны мөн үеэс 21,1 хувиар өсөж, 15,2 тэрбум ам.доллар хүрэхэд нүүрсний экспорт 36,8 хувиар буюу 2,4 тэрбум ам.доллаароор өссөн нь голлон нөлөөллөө.

Засгийн газрын 2022 оны валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээний тухай 362 дугаар тогтоолын хүрээнд экспортод гарах нүүрсийг нээлттэй цахим арилжаагаар хийж, хилийн үнээр борлуулж боомтуудын нэвтрүүлэх чадварыг сайжруулснаар 2022 онд 0,7 тэрбум ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл 2023 онд 1,5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын нөөц оны эцэст 4,9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 44,7 хувиар өссөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 23,3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,5 их наяд төгрөг. Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 2,2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785,9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 16,1 их наяд төгрөг, зарлага 16,1 их наяд төгрөг, нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1,8 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 5,4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Сүүлийн жилүүдэд Засгийн газар хилийн боомтын нэвтрэх хүчин чадлыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажилласны үр дүнд 2023 онд нүүрсний экспортын хэмжээг төлөвлөсөн хэмжээнээс 19,6 сая тонноор, өмнөх оноос 37,8 сая тонноор нэмэгдүүлж, 69,6 сая тоннд хүргэсэн нь төсвийн орлого нэмэгдүүлэхэд гол нөлөөг үзүүллээ.

2023 онд авч хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээнүүдээс тоймловол төрийн албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээг төрийн захиргааны албан хаагчид 39,3 хувь, төрийн тусгай албан хаагчид 39,4 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчид 32,7 хувь, төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчид 69,2 хувиар тус тус нэмэгдүүлж, олон шатлал бүхий харилцан адилгүй, тэгш бус үнэлэмжтэй цалингийн тогтолцоог адил үнэлэмж бүхий нэг шатлалтай болгосон. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн зөрөөг арилгах зорилгоор даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг өнөөгийн цалин хөлсний түвшинтэй жишиж ойртуулах итгэлцүүрийг 2023 онд суурь оныг нь 2011 он байсныг 2022 он болгож шинэчлэн тогтоолоо. Итгэлцүүрийг ашиглан тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас

тооцож, тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг шийдвэрлэснээр тэтгэвэр авагч ахмадуудын орлогын баталгаа сайжирч, бараа бүтээгдэхүүн, үнийн өсөлтөөс үүдэлтэй эрсдэлийг буурууллаа.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хот, хөдөөгийн сэргэлт хэт төвлөрлийг сааруулах зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгох, орон нутгийн удирдлага нь төрийн албан хаагчдынхаа цалинг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгох эрх зүйн орчныг бий болгосноор тайлант онд 35,1 тэрбум төгрөгийн цалингийн нэмэгдэл олголоо.

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зохистой удирдаж зарцуулсантай холбогдуулан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагаас бусад байгууллагын 23602 албан хаагчдад 25,7 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 1143 төсөл, арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлсэн 10 төсөл, арга хэмжээнд 0,5 их наяд төгрөг, өмнөх онуудаас шилжин хэрэгжиж буй 1129 төсөл, арга хэмжээнд 2,1 их наяд төгрөг, концессын эргэн төлөлтөөр 4 төсөл, арга хэмжээнд 0,2 их наяд төгрөг олгосноор гүйцэтгэл 93,8 хувийн биелэлттэй байна.

Мөн эдгээр төслүүдийг гүйцэтгэсэн 1460 гаруй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтворжиж, тогтвортой үргэлжилж, 40,9 мянган ажлын байрыг хадгалж, 2,8 их наяд төгрөгийн санхүүжилтээр эдийн засгийг дэмжсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа, зардал тавих хяналтыг сайжруулан санхүүгийн сахилга батыг мөрдүүлснээр 2023 оны төсвийн жилд 122,8 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсгэж, өмнөх оноос 39,4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулгатай танилцаж Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн төслийг хэлэлцэн баталж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Батбаяр: Тулга сайдад баярлалаа. Одоо Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тус тус хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав уншиж танилцуулна. Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Д.Загджав: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Улсын Их Хурлын Зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь хуульд заасан шалгуур үзүүлэлтүүд, төсвийн зорилтыг хангасан эсэхэд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг стандартын дагуу үнэн, зөв илэрхийлсэн эсэхэд Төрийн аудитын байгууллага аудит хийж, дүгнэлт гарган хуулиар тогтоосон хугацаанд аудитын тайланг Улсын Их Хуралд хүргүүлсэн болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2023 оны төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 23 их наяд 294,9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 22 их наяд 509 тэрбум төгрөгөөр аудит хийж баталгаажууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 1 их наяд 547,5 тэрбум төгрөгөөр давж, урсгал зарлагыг 988,2 тэрбум төгрөг хөрөнгийн зардлыг 1 их наяд 28,6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулан эргээж төлөгдөх цэвэр зээл 292,8 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2 их наяд 213,1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 785,9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Засгийн газрын нийт өр 2023 оны эцэст 30 их наяд 773,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өнөөгийн үнэ цэнээр тооцвол 26 их наяд 582,9 тэрбум төгрөг болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 38,6 хувьтай тэнцэж, өрийн үлдэгдэл өмнөх оноос 1 их наяд 108,7 тэрбум төгрөг буюу 4 хувиар буурсан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 7 их наяд 376,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1139 төсөл, арга хэмжээг 2 их наяд 686 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан ба тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 83,2 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 883 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 62,5 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгцээт шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр эрэмбэлээгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нь уялдуулж төлөвлөөгүй, хэрэгжилтэд тулгарсан асуудлыг шийдвэрлэх хугацаа, шат дараалалд тодорхойгүй, гэрээний хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширах, зогсонги байдалд хүргэхэд нөлөөлж, төсөл өртөг нь нэмэгдэх шалтгаан болж байна.

Аудитын дүгнэлтэд үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчид 11 зөвлөмж өгч, илэрсэн зөрчилд 8 тэрбум 249,9 сая төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 28 тэрбум 615,4 сая төгрөгийн 15 албан шаардлагыг хүргүүлсэн. Засгийн газрын 2023 онд санхүүгийн нэгдсэн тайлан төсвийн ерөнхийлөн захирагчийн 62 санхүүгийн нэгтгэсэн тайлан тэдгээрийн харьяа байгууллагуудын нийт 6711 санхүүгийн тайланг аудитад хамруулсан. Аудитаар нийт нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 3 их наяд 845,9 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 3 их наяд 794,5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, хууль тогтоомж зөрчсөн 4 их наяд 291,4 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлээ. Нийт 62 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 34, хязгаарлалттай 28 дүгнэлт өгсөн.

Аудитаар Улсын Их Хуралд 4 асуудлыг толилуулж, Монгол улсын ерөнхий сайдад 9, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 5, Сангийн сайдад 15, төсвийн ерөнхийлөн захирагчид 5 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудит дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын хороодод танилцуулсан болно.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Одоо ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Өнөөдрийн дэд хорооны хуралд Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр байхгүй байна. Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан байна уу. Байхгүй байна.

Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд байхгүй байна. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал байхгүй байна. Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга Эрдэнэбилэгийн Одбаяр байхгүй байна. Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга хүрэлцэн ирсэн байна. Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Равжихын Эрдэнэбүрэн байхгүй байна, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг хүрэлцэн ирсэн байна. Сангийн сайд Болдын Жавхлан байхгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл байхгүй байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан байхгүй байна. Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт байхгүй байна. Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа ар гэрийн гачигдалтай, чөлөө авсан байна. Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр хүрэлцэн ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан байхгүй байна. Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан байхгүй байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Чинбатын Номин байхгүй байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Жамбын Батсуурь байхгүй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр байхгүй байна. Цахим хөгжил, инновац харилцааны холбооны сайд Цэндийн Баатархүү байхгүй байна. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн байхгүй байна. Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан байхгүй байна. Засгийн газрын ирц, манай хуралд ирж байгаа Засгийн газрын ирц иймэрхүү байна.

Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр ирсэн байна. Санхүүгийн зохицуулах хорооны дарга

Дэмбэрэлдашийн Баярсайхан ирсэн байна. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнаран байхгүй байна. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Бат-Эрдэнэ байхгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат байхгүй байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Отгонтуяа ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Дэлгэрсайхан ирсэн байна. Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван ирсэн байна. Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням ирсэн байна. Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг ирсэн байна. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг. Сайд ирчихсэн байгаа учраас дуудахаа больё. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү ирээгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар ирсэн байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн ирээгүй байна. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг ирсэн байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Баттулга ирээгүй байна. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул ирээгүй байна. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батболд ирээгүй байна. Сангийн сайд Болдын Жавхлан хүрэлцэн ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн ирээгүй байна. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Тавинбэх ирээгүй байна. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат ирээгүй байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн

бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Даваажаргал ирээгүй байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Төмөрхүү ирээгүй байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтан-Од ирсэн байна. Монголбанкны Ерөнхий эдийн засагч Ган-Очир ирсэн байна. Гаалийн ерөнхий газрын дарга Отгонжаргал ирсэн байна. Татварын ерөнхий газрын дарга Чимэдсүрэн ирээгүй байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа ирээгүй байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга Эрдэнэсайхан ирсэн байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Бямбасүрэн ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганцэцэг ирсэн байна. Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлтийн бодлогын газрын захирал Ариунбат ирсэн байна. Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Нарандалай ирсэн байна. Монголбанкны Капитал банкны эрх хүлээн авагч Дэлгэрхүү ирсэн байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, эдийн засгийн газрын дарга Бямбасүрэн ирсэн байна. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Бэлтрэгийн Цогбадрах ирсэн байна. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж ирсэн байна. Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Баасанжавын Болор-Эрдэнэ ирээгүй байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Цэвээн-Ойдовын Ариунсанаа ирсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантуяа ирсэн байна. Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг ирсэн байна. Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн

яамны Хяналт үнэлгээ, аудитын газрын дарга Буяннэмэх ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Жигжидсамбуугийн Отгонбат ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Лувсангийн Идэрцогт ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Очирваань ирсэн байна. Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Лхагважавын Лувсан ирээгүй байна. Үндэсний Аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд ирсэн байна. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа ирээгүй байна. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Оюунхүү ирсэн байна. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор Идэрбалжинням ирсэн байна. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор Нямжаргал ирсэн байна. Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга ирээгүй байна. Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Нарангийн Мөнхсүх ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг ирсэн байна. Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга Ванчингийн Рэнцэнханд ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамбалын Энхтөр ирээгүй байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Пүрэв-Очирын Дэлгэрмаа ирсэн байна. Хот байгуулалт, барилга, орон

сууцжуулалтын яамны Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Мөнгөнцэцэг ирсэн байна, Эрчим хүчний яамны Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Баярсайханы Баясгалан ирээгүй байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Жаргалсайханы Гэрэлбат ирээгүй байна. Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Оюунгэрэл ирсэн байна. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва ирсэн байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын Ажлын албаны дарга Очирсүрэн ирсэн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Баяр-Эрдэнэ ирсэн байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Энхжин ирчихсэн байна. Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга Баярмаа ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Даваахүү ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Баасангийн Алтанцэцэг ирсэн байна. Үндэсний статистикийн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Буураагийн Төмөрхуяг ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч Амгалан ирсэн байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ерөнхий нягтлан бодогч Оюунчимэг ирсэн байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бас төлөөлөл ирсэн байна. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал ирсэн байна. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Түвшинжаргал ирсэн байна. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантулга ирсэн байна. Ерөнхий нягтлан бодогч Цогзолмаа ирсэн байна. Төрийн банкны гүйцэтгэх захирал Гантөр ирсэн байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат ирсэн байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74.4.2-т заасны дагуу бусад Байнгын хороод, нам, эвслийн бүлэг уг асуудлаар 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн байгаа. Ингээд бусад Байнгын хороодын ирүүлсэн санал, дүгнэлттэй танилцъя.

Эхлээд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Дамдинням гишүүний микрофоныг нээе.

Г.Дамдинням: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон холбогдох бусад Байнгын хороонд тус тус шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 74.4.2 дахь хэсэгт заасан журмын дагуу уг Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал төрийн өмчийн их дээд сургуулиуд аудитын хязгаарлалттай дүгнэлт авсан шалтгаан, Боловсролын зээлийн сангийн авлага, эргэн төлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Боловсролын зээлийн сангийн журмыг тодорхой болгох, Биеийн тамир, спортын улсын хорооноос олимпод амжилтгүй оролцсон шигшээ баг, спортын холбоодод хариуцлага тооцох эсэх талаар, Дарханы музей, номын сангийн цогцолборын гүйцэтгэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа болон гадаадад оюутнуудыг сургах бодлогыг хэрхэн сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн санхүүжилтийн системийг шуурхай болгох талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Гадаадад боловсон хүчин бэлтгэх бодлогыг өөрчлөх, дотоодын их, дээд сургуулиудад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Боловсролын яам, Боловсролын зээлийн сангаас гадаад, дотоодод олгосон зээлийн мэдээллийн жагсаалтыг Монголбанканд жил бүр хүргүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Байгалийн ухааны чиглэлээр багш, боловсон хүчин бэлтгэхэд түлхүү анхаарч, боловсролын салбарын чанар стандартыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт чухал байгаа талаар санал хэлсэн болно.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Дараагийнх нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр уншиж танилцуулна. Хосбаяр гишүүний микрофоныг нээнэ үү.

Г.Хосбаяр: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төсвийн зарлагын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр төсвийн гүйцэтгэлийн биелэлт бүрэн хангагдсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хөдөө, орон нутагт төрийн албан хаагчдын орон тоо дутуу байгаагаас иргэдэд төрийн үйлчилгээ бүрэн хүрч чадахгүй байгаа талаар, тухайн орон тооны цалин, зардал болон төсвийн гүйцэтгэлд хяналт тавьдаг эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хороо Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын дэд хороонд хүргүүлж байна.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан гишүүний микрофоныг нээнэ үү.

З.Мэндсайхан: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод илжжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан Хоршоо хөгжүүлэх сан болон шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагаа хоорондоо хэрхэн уялдах, төрийн өмчит компаниудын санхүүгийн алдагдал, засаглалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Орон нутагт хэрэгжүүлж байгаа Шинэ хөдөө

төслийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг салбарын эдийн засгийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйл болон 2023 онд Мал эмнэлгийн чиглэлээр явуулсан үйл ажиллагааны үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай Шинэ Ховд үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилт, гүйцэтгэлийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг Шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагаа, зохион байгуулалтыг эрчимжүүлэх явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хороонд танилцуулах, Улсын Их Хурлын гишүүн Идэрбат Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо үндэсний хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас аялал жуулчлалын чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулж 2024 онд эхэлсэн салбарын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэн ирэх оны төсөвт санхүүжилтийг нь тусгах зэрэг саналыг хэлсэн болно.

Монгол Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын

гишүүн Баярмаа танилцуулна. Баярмаа гишүүний микрофоныг нээе.

Ж.Баярмаа: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа уг тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Найдалаа Төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр эрх бүхий албан тушаалтнуудад ногдуулсан холбогдох сахилгын шийтгэл, албан шаардлагын тоо, түүний биелэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн явц, Засгийн газрын тусгай сангуудаас олгогдсон зээлийн эргэн төлөлт, үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир төсвийн гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналтыг хэрхэн бий болгох, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсох талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан зөвлөмж,

албан шаардлага биелүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох арга хэмжээ хангалтгүй байгаа шалтгаан нөхцөл хариуцлагыг нэмэгдүүлэх боломжийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар төсвийн гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Шижир аудитын зөвлөмж, дүгнэлтийг нээлттэй болгох, иргэдийг мэдэх эрхээр хангах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа төрийн өмчит компаниудын санхүүгийн ашиглалт, зарцуулалт, гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар анхаарч ажиллах, төрийн аудитын байгууллагын эрх зүйн байдлыг эргэн харах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Төрийн аудитын тухай хуулийг боловсронгуй болгох, аудитын зөвлөмж, дүгнэлт, албан шаардлага нэг мөр хэрэгждэг байх эрх зүйн өөрчлөлтийг хийх нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна. Заяабал гишүүний микрофоныг нээе. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн Мөнхсоёл уншина. Мөнхсоёл гишүүний микрофоныг нээе.

Б.Мөнхсоёл: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод илжжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Сэددорж санхүүгийн тайланд тусгагдсан гүйцэтгэлээр Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах салбарын төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн гүйцэтгэлийг дутуу зарцуулсан болон аудитын хязгаарлалттай дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцаас ямар төслийн ТЭЗҮ боловсруулах зардлыг хэмнэсэн, тухайн төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн 2025 оны төсвийн төсөлд тусгасан эсэх, Төрийн банкны ноогдол ашгаас орлого төвлөрүүлэх гэсэн аудитын дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн

Батболд он дамжиж төсвөөс санхүүждэг анхны төсөвт өртөг нь нэмэгдсэн хугацаандаа ашиглалтад ороогүй хэдэн төсөл арга хэмжээ байгаа талаар, тэдгээрийг цаашид хэрхэн зохицуулах талаар болон Үндэсний аудитын газрын зөвлөмжийн хэрэгжилтэд хэн хяналт тавьдаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахушиг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Улаанбаатар хотын ногоон байгууламж төсөл саатсан шалтгааны талаар, Төсвийн хөрөнгөөр баригдсан барилга, байгууламжийг ашиглахгүй байгаа шалтгаан, тэдгээрт тавигдах хяналтыг сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг улсын төсвийн худалдан авалтын хэдэн гэрээг гадаадын компанитай байгуулсан, үүний төсөвт өртөг нийт худалдан авалтын хэдэн хувийг эзэлж байгаа талаар, улсын төсвийн хөрөнгөөр баригдсан барилгын чанар болон чанарын хариуцлагын асуудлыг хэрхэн зохицуулах талаар, 3-аас дээш жил хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ тэдгээрийн анхны төсөвт өртөг хэдэн хувиар өссөн талаар, эрчим хүчний салбарын нормчлолын санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө зарцуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай батлагдсан төсвийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, сангуудын гүйлгээ зардлыг нэгдсэн журмаар төрийн сангаар дамжуулах боломжийн талаар, 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр орлого давж биелсэн, зарлага хэмнэлттэй гарсан хэдий ч бусдаар гүйцэтгүүлэх ажлын хураамж өссөн шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал уул уурхайн бүтээгдэхүүний орлогоос жилдээ дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьтай тэнцэх хэмжээний хуримтлал үүсгэдэг байх, гадаад өр, зээлийн үлдэгдэл цаашид гадаадын зээлийг хэрхэн ашиглах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг хөрөнгийн бирж дээр нийт 25 аж ахуйн нэгжийг нээлттэй ХК

болгох асуудал хангалтгүй байгаа шалтгааны талаар, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааг цаашид хэрхэн зохицуулах талаар, Чингис Хаан банканд байришиж байгаа мөнгөн хөрөнгөд үүссэн эрсдэл, зохистой харилцааны талаар, Бэрэн хязгаарлагдмал ХК-тай зарим яамдын байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд мөнгөн суурьтай бүртгэлийг олон улсын бүртгэлийн стандартад ойртуулах, жижиг аж ахуйн нэгжүүдийн нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг багасгахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансаа ил тод, нээлттэй хөтлөх, эрчим хүчний шинэтгэл хийх, барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг барилгын чанартай холбож, чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцалдаг байх, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал Санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлдэг байх, төрийн байгууллагууд шилэн дансаа ил тод, нээлттэй хөтөлдөг байх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, 2024 оны төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, энэ талаар олон нийтэд мэдээлдэг байх гэсэн санал хэлсэн болно.

Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн

нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна. Заяабал гишүүний микрофоныг нээе.

Б.Заяабал: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод илжжүүлсэн болно.

Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны

дагуу төсвийн гүйцэтгэлийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт болон арилжааны банканд байршуулсан хөрөнгийн талаар, Боловсролын зээлийн сангийн зарцуулалтын талаар, 2023 оны төсөвт туссан тендергүй зарцуулалт болон илэрсэн зөрчилтэй холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар, төрийн өмчийн компанид гадаадын зээл тусламж олгосон, түүний эргэн төлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн тэргүүтэй төрийн өмчийн оролцоотой компаниудын хооронд үүссэн өр, авлага болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ноогдол ашигаа төсөвт төвлөрүүлээгүй шалтгааны талаар, Нийслэлийн амьдрах орчныг дээшлүүлэх, түгжрэлийг бууруулах гол дагуу дэд бүтцийг сайжруулах зорилго бүхий холбоос зам, төслийн хэрэгжилт, зарцуулсан хөрөнгөд гүйцэтгэлийн аудит хийсэн эсэх талаар, Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг гаалийн албан татвараас бүрэн чөлөөлсний үр дүнд Монгол Улсад шинээр үйлдвэр байгуулагдсан эсэх талаар, 2016 оноос хойш Төрийн сангийн чөлөөт мөнгөн үлдэгдэл арилжааны банканд хэрхэн хуваарилагдаж байршсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэг шалгуур болох дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эрдэс баялгийн бус бүтээгдэхүүний зардлын өсөлтийг тооцохдоо уул уурхайн салбар дахь тээврийн салбарын өсөлтийг оруулж тооцсон эсэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлсөн татвар нийт татвар төлөгчдийн хэдэн хувийг эзэлж байгаа талаар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

сангийн хөрөнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт дэх 17 зөвлөмжийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн 2023 оны чөлөөт үлдэгдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Аудитын дүгнэлтэд тусгасан төсвийн тодотгол хийх тухай бүр төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг өөрчилж байгаа үндэслэл, шалтгааны талаар, Аудитын байгууллагаас өгсөн хязгаарлалттай дүгнэлтийн талаар, Засгийн газрын өр, авлага, урьдчилгаа төлбөр, зээлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут төсвийн гүйцэтгэлээр 400 орчим төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсний 200 орчимд нь нийслэлийн аудитын байгууллагаас аудит хийж, 80 орчим тэрбум төгрөгийг илүү тооцсон шалтгааны талаар, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөс хувийн эмнэлэгт зардал өгч байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан Хөдөө аж ахуйг дэмжих санг төрийн өмчид компани болгосонтой холбогдуулан хөрөнгийн үр ашигтай зарцуулсан эсэх талаар, Засгийн газрын тусгай сангуудын үр ашгийн талаар, Төрийн өмчит компанид хувийн хэвшилтэй өрсөлдөж байгаа эсэх талаар, Чингис Хаан банк, Капитал банканд томилогдсон бүрэн эрхт төлөөлөгч дараагийн шатын арга хэмжээг хэрхэн авч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар Төрийн банк төсөвт төвлөрүүлэх ноогдол ашгийг бүрэн төлсөн эсэх, төрийн өмчийн гэдгээр хувийн хэвшлийн арилжааны банкнуудаас давуу эрх эдэлж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир хөдөө аж ахуйн салбарт олгож буй татаас, хөдөө аж ахуйн нэг цонхны бодлогын хэрэгжилтийн талаар, Төв банкны хэрэгжүүлж буй мөнгөний бодлого, төсвийн бодлогын нийцлийн талаар, нүүрсийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр бүрэн

арилжаалж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд байгалийн баялгийн сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэл болгож, үр ашигтай зарцуулж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Үндэсний аудитын газрын гаргасан дүгнэлттэй санал нэг байгаа эсэх талаар холбогдох албан тушаалтнуудаас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг төсвийн хяналтыг сайжруулах, төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, ил тод, шилэн болгох, Улсын Их Хурлын 16 дугаар тогтоолын биелэлтийг хангуулах зайлиггүй шаардлагатай талаар, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг үр дүнтэй зарцуулах, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл дэд бүтцийн шинжтэй том төслүүдэд зардал үр ашгийн тооцооллыг хийж, төсөвт тусгах эрэмбэ, дарааллын оновчтой тогтоох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангуулж, засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон нийтэд нээлттэй арилжаалах, Үндэсний аудитын газрын өгсөн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Үндэсний аудитын газрын бие даасан хараат бус байдлыг хангахад анхаарч боловсон хүчний чадавхыг сайжруулах, гаргасан зөвлөмж, дүгнэлтүүдийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг дэмжих, төрийн өмчит компанийг багасгах, нэгтгэх, нийлүүлэх, олон нийтийн хяналтад оруулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Мэргээжлийн байгууллагууд дүгнэлт, зөвлөмжүүд гаргахдаа олон нийтэд зөв мэдээлэл хүргэхэд анхаарч ажиллах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Галбадрах танилцуулна. Галбадрах гишүүний микрофоныг нээе.

Ж.Галбадрах: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн.

Инновац, цахим бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд и-Монгол системийн өртөг, хөрөнгийн бүртгэл, Засгийн газар, яамдын нэгдсэн ер

системтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах и-Монгол системийн аюулгүй байдал, төсөв, хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн төсвийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам эрүүл мэндийн салбарт Дэлхийн банкнаас санхүүжүүлсэн төслийн санхүүжилт татагдсан, хууль хяналтын байгууллагаар шалгуулсан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулсан эсэх, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн эрчим хүчний реформтой холбоотой ухаалаг тоолуур, их өгөгдлийн шийдэл, эдийн засгийн үр өгөөжийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Инновац, цахим бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа танилцуулна. Булгантуяа гишүүний микрофоныг нээе.

Х.Булгантуяа: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон бусад Байнгын хороонд ишлэжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого нэмэгдсэн боловч сангийн орлого нэмэгдсэн боловч сангийн төсөв 16,6 тэрбумаар тасарсан асуудал болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын төсвийн гүйцэтгэл болон зарцуулалтын үр дүнг тооцсон аргачлалын талаар, Монголын эмэгтэйчүүдийн холбооноос хэрэгжүүлсэн Эрүүл Монгол хөтөлбөрт улсын төсвөөс санхүүжилт олгосон эсэх талаар Улсын Их Хурлын гишүүн

Б.Бейсен Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй, гадаад улсад эмчлэгдэх өвчний заалтаар олгосон санхүүжилт, он дамнасан эмнэлгийн барилгуудын үлдэгдэл санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нь Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкнуудад байршуулан алдсан асуудлыг шийдвэрлэлт болон аудитын дүгнэлтээр зөрчилтэй гарсан байгууллагуудын хариуцлага алдсан албан тушаалтнуудад авах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Эхнасан Эрүүл мэндийн даатгалын сангийн 218 тэрбум төгрөгийн өглөгийг хэрхэн шийдвэрлэх талаар төсвийн гүйцэтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний ажлыг тодорхой болгох, эмнэлгүүдийг стандартын шаардлага хангасан байртай болгоход эрүүл мэндийн сайд онцгой анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен Эрүүл мэндийн даатгалын болон Нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл өр, авлагын асуудлыг хууль хяналтын байгууллагууд хамтран холбогдох сайд нар шуурхай арга хэмжээ авч шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа цаашид төсвийн үргүй зардлыг бууруулах, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцож, хохирлыг барагдуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа батлагдсан төсвийг зориулалтын дагуу ашиглалгүй хэмнэлт гаргаж байх нь зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээнүүд хэрэгжихгүй, үр дүн гарахгүй байгааг анхаарч, цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах талаар саналаа хэллээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг миний бие уншиж танилцуулна.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” “Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь

хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин улсын төсөвт төвлөрүүлсэн хүү, торгууль, торгуулийн орлогын задаргаа болон уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ, биржгийн үнийн зөрүүний талаар, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа Байнгын хорооны эрхлэх асууд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнгийн гүйцэтгэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Очирбат Өмнөх онуудын аудитын зөвлөмжийн хэрэгжилт болон төрийн өмчит компаниудын санхүүгийн үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны талаар, Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа Дарханы арьс шир, цогцолборын бүтээн байгуулалтын явц болон улсын төсвөөс олгосон санхүүжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа томоохон төслүүдийн хэрэгжилтийн явц, мөн “Тавантолгой түли” ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүд “Тавантолгой түли” ХК-ийн үйл ажиллагаатай танилцах, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа Байнгын хорооны эрхлэх асуудлын хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэл нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлд үзүүлж байгаа нөлөөллийн талаар Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж байх, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин Эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбарын тээвэр болон тус салбарын аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогуудын нөлөөлөл их байгааг анхаарах, Улсын Их Хурлын

гишүүн Золжаргал Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 онд зарцуулсан норматив зардлын дүн бага байгааг анхаарч, цаашид нэмэгдүүлэх нь зүйтэй гэж хэлсэн болно.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Одоо Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал уншиж танилцуулна. Заяабал гишүүний микрофоныг нээе

Б.Заяабал: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл дээр төрийн албан хаагчдын урамшуулал нь батлагдсан төсвийн хүрээнд байгаа боловч өндөр дүнгээр хэтрэлттэй гарсан шалтгаан болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир санхүүгийн зөрчил дутагдал гардаг шалтгаануудын нэг нь санхүүгийн мэргэжлийн ажиллах хүчний дутагдал болон ур чадварын асуудал гэдгийг хэлээд, энэ асуудал дээр салбарын баримталж байгаа бодлогын талаар мөн орон нутагт ажиллаж байгаа хуулийн салбарын албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Одоо Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг миний бие бас уншиж, танилцуулах юм байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон холбогдох бусад Байнгын хороонд тус тус шилжүүлсэн.

Ёс зүй, дэгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74.4.2 дахь хэсэгт заасан журмын дагуу дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад Төрийн албаны зөвлөлийн төсөвт Ёс зүйн хорооны төсөв хэрхэн туссан, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарал тавьж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Очирбат Монгол Улсын Засгийн газрын 2023 онд 72 хувийн төсвийн гүйцэтгэлтэй, 117 их наяд төгрөгийн өртэй ажилласны ихэнх өрийг төрийн өмчит үйлдвэрийн газрууд бий болгож, 26 хувийн алдагдалтай ажилласан. Олон жил үргэлжилж байгаа төсөл хөтөлбөрүүдийг жил бүр санхүүжүүлэн ажиллаж байгааг анхаарах, Үндэсний

аудитын газрын зөвлөмжийг гүйцэтгэх засаглал хэрэгжүүлж ажиллах, алдагдсан боломжийг тооцож тоон мэдээллээр хангах, Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар Хөрөнгө санхүү зарцуулах нь ёс суртахууны нэг хэлбэр бөгөөд цаашид ёс зүйн индексийг бий болгож мөрдүүлэхээр ажиллаж байгаа талаар санал хэлсэн болно.

Дэд хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хороодоос гаргасан санал дүгнэлтүүдтэй танилцлаа.

Одоо Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагчдаас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Нэрс авъя. Үг хэлэх юм уу Баярмаа гишүүн ээ. Асуулт асуух юм уу. Тэгвэл Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Батболд гишүүнд микрофон өгье.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Үндэсний аудитын газрын тайлан бол орж ирээд 2 хоногийн дотор хэлэлцээд ингээд яваад байна. Би энэ төсвийн ерөнхийлөн захирагч нараас 1 асуулт асуух гэсэн юм. Та бүхэн дээр энэ 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд

хийсэн аудитын тайлан очсон байдаг байх. Ингээд маргааши гээд энэ чинь 2024 оны 3 дугаар улирал дуусах гэж байна. Тэгэхээр Аудитын газраас өгсөн зөвлөгөө, шаардлагуудын биелэлт нь ямархуу явж байдаг юм. Та нар дээр ийм тайлан өнөөдрийн байдлаар гарч явдаг уу, үгүй юу. Хэчнээн хэмжээний төсөл, арга хэмжээний зөрчил арилсан бэ. Энэ талаар хариулт авъя. Нийт яамнуудад харьяалуулж хэлж байгаа шүү.

Д.Батбаяр: Аудитын газраас асууж байгаа шүү дээ.

Р.Батболд: Үгүй, үгүй. Аудитын газар биш. Яамнуудаас.

Д.Батбаяр: Тэгэхээр одоо яах вэ. Ерөнхийд нь хариулчих хүн байна уу. Энэ дээр ерөнхийлөөд хариулах арга байна уу. Хэрэг эрхлэх газраас хариулах уу.

Р.Батболд: Эсвэл аудитын газар дээр эргээд энийгээ хянасан юм байдаг юм уу тэрийгээ танилцуулах юм байдаг юм уу.

Д.Батбаяр: 6 номерын микрофоныг нээе. Наранчимэг дарга хариулах уу.

Ц.Наранчимэг: Гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитыг төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2-т заасны дагуу цаглаварт хугацаанд хийж гүйцэтгээд, төсвийн захирагч бүрд дүгнэлт гарч байгаа байгууллагуудын төсвийн захирагч бүрд хуулийн хугацаанд тайлангуудыг нь хүргүүлж байгаа. Аудитын тайланд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлэх хугацаатай нь хүргүүлж байгаа учраас бүх шатны төсөвт захирагч нар аудитаас өгсөн энэ шийдвэрийг хэрэгжүүлэх хугацаа, төлөвлөгөөгөө гаргаад ажиллаж байгаа.

Бид энэ 2023 оны Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон бүх шатын төсөвт захирагч нарт өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 9 дүгээр сарын 5-аас эхэлж давтан аудит хийхдээ үнэлж, үнэлгээг мөн хэрэгжилтийг тухайн тайланд нь тусгаж ингэж ажилладаг байгаа.

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуульд өөрчлөлт ороод аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцдог ийм зохицуулалттай болсон. Тэгэхээр энэ зохицуулалтын дагуу бид нар биелэлтээ гаргаад, тайлангаа мөн 2024 оны 6 сарын 10-ны дотор Улсын Их Хуралд хүргүүлэх ийм хуулийн зохицуулалттай. 2025 оны 6 сарын 10-ны дотор хүргүүлэх зохицуулалттай байгаа.

Д.Батбаяр: Тодруулга авах уу та. Болчихсон уу. Батболд гишүүний микрофон. 1 минутыг өгье.

Р.Батболд: Ер нь бол 2025 оны төсөв боогдчихсон байгаа байх. Тэгэхээр энэ тал дээр та нар дээр бэлэн материалууд чинь байдаг байх гэж бодож байна. Тэгэхээр 39 газраас хариулт өгөхөөр болсон учраас энэ удаадаа орхичихлоо. Тэгэхдээ 9 сарын 15-нд ч юм уу багтаагаад энэ тал дээр гүйцэтгэл нь ямархуу явж байгааг төсвийн ерөнхийлөн захирагч нар тайлан ирүүлээч гэдэг юмыг энэ Төсвийн байнгын хорооны гишүүдэд ер нь яг хэчнээн хэмжээний зөрчилтэй төсөл арга хэмжээнүүд яваад байна. Сангийн хөрөнгө яаж зарцуулагдаад байна. Хэчнээн хувь нь найдваргүй авлага юм уу, болчихоод яваад байгаа юм. Энэ тал дээрээ тайлан ирүүлээч гэж хүсэж байна.

Д.Батбаяр: Бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар бүгдээрээ тайлангаа 9 сарын 15-ны дотор гэсэн үү. Хугацаа заачихсан уу.

Р.Батболд: Тийм хугацаа заагаад 9 сарын 15-ны дотор энэ төсвийн байнгын хорооны гишүүдэд бүгдэд нь хүргүүлээч л гэдэг.

Д.Батбаяр: Баярлалаа. Одоо Ганзориг гишүүний микрофон.

П.Ганзориг: Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн 3 дугаар бүлэг дээр улсын төсвийн нийт зардалд эзлэх урсгал зардлын хэмжээ гээд. Энэ маань бол сүүлийн 5 жилд дунджаар 77 хувьтай байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжих тал дээр бол үр ашиггүй байна гэсэн ийм тодорхой заалт байж байна. Энэ бол яалт ч байхгүй эдийн засгийн яг үр ашгийг өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтын зардлуудыг бууруулж байгаа нэг юм бол урсгал зардал өсөх байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодлого барих юм бэ. Үндэсний аудитын газраас ингээд төсвийн зардал дээр маш тодорхой ийм дүгнэлтүүд өгөөд яваад байгаа. Тэгэхээр энийг бас нэгд холбогдох Сангийн яам юм уу газраас асуумаар байна. Ер нь ингээд шат шатандаа төсөв тавих болохоор төсөв мөнгө хүрэхгүй байна. Хүрэлцэхгүй байна гээд л. Ялангуяа энэ тойргууд дээр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтууд дээр гишүүд нэлээн юм болдог. Гэтэл урсгал зардал өөрөө тодорхой түвшинд ч юм уу бодлогоор, төсвийнхөө зардал талын бодлого дээр тодорхой суухгүй болохоор урсгал зардал өсөөд байдаг. Тэгэхээр ер нь цаашидаа төсвийн урсгал зардлыг ямар үе шаттайгаар яг эзлэх хувиар нь гэдэг юм уу барих ийм бодлого байгаа юм бэ. Абсолют дүнгээр бол өсөөд явах байх. Тэгэхдээ тодорхой хувь дээр бол тодорхой хэмжээгээр бууруулж байж тэгж байж хөрөнгө оруулалтын зардлууд бас орон зайнууд бол гарах болов уу гэж бодож байна.

2-т энэ төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа асар олон ажлууд байж байгаа. Ялангуяа энэ дэд

бүтэц, бүтээн байгуулалтын ажлууд олон жил сунжирчихдаг. Тэгээд нөгөө гүйцэтгэж байгаа компаниуд нь ч маш их хүндрэлтэй. Үнийн өсөлт, зээлийн хүү гээд олон юманд ингээд баригдаад ажлаа явуулж чадахгүй. Улсад ч тэр төсөл хөтөлбөрөө ашиглалтад оруулж ашиглаж чаддаггүй. Энэ дээр маш тодорхой энэ гацчихсан байгаа төслүүдийг хурдан дуусгаж, 2-т ер нь цаашидаа эхлээд тавихдаа тэр хөрөнгө оруулалтууддаа богино хугацаатай 2 жил дотор ч байдаг юм уу бүтээн байгуулалтын ажлыг нь хийхээр эхний жилүүдэд нийт төсвийнх нь 30, 40 хувь ч байдаг юм уу тодорхой хувиудыг тавьж өгөхгүй бол энэ байдал цаашидаа ер нь сунжраад л яваад байх шинжтэй юм байна лээ. Энэ дээр ямар бодлого байгаа вэ. Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх дээр.

3-д төсвийн яах вэ, зүгээр орлого тал, ялангуяа татварын орлого бол өнгөрсөн жил гээд тэгэхэд 8 орчим хувиар давж биелсэн байна гэж байна. Төсвийнхөө орлогыг биелүүлэхдээ ялангуяа татварын орлого дээр бол бид нар аж ахуйн нэгжүүдээсээ төрийн өмчит компаниуд гээд бусад татварын төрлүүдээр орлогоо бүрдүүлчхэж байгаа юм. Хувийн хэвшлүүдийг бол бид нар ялангуяа дансыг нь хааж байгаад, торгож байгаад ингээд авчихдаг. Тэгээд нөгөө бүрдүүлсэн төсвөө буцаагаад хэр үр ашигтай байршуулж байна вэ. Ялангуяа Засгийн газар болон төсвийн байгууллагуудын мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлүүд, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангуудын чөлөөт үлдэгдэл мөнгөнүүдийг арилжааны банкнуудад байршуулж байгаа. Энэ дээр ямар хүүтэй байгаа вэ.../минут дуусав/

Д.Батбаяр: 1 минут нэмээд өгчихье.

П.Ганзориг: Энэ мөнгөн хөрөнгүүд ямар хүүтэй байришж байгаа гээд өчигдөр асуусан. Эрүүл мэндийн

даатгалын сан, Нийгмийн даатгалын сангийн мөнгө бол хүүгүй байгаа гээд 7 хоногтойгоо хариулж байх шиг байна лээ. Тэгээд энэ чинь өөрөө ингээд төсвийн мөнгөний үр ашигт маш чухал нөлөөтэй зүйл шүү дээ. Иргэд, аж ахуйн нэгжүүд банкнаас зээл авах болохоороо жилийн 20, 30 хувьтай зээл асар өндөр хүүтэй, маш өндөр шалгуур хангаж байж авч байгаа. Тэгээд энэ банкнуудыг дагасан банк бусуудаас бүр 30, 40 хувьтай зээлүүд авч байгаа шүү дээ. Тэгээд төсвийн мөнгөний орлогын чинь тодорхой хэсгийг аж ахуйн нэгж, иргэд бүрдүүлж байгаа. Татварын орлогоороо. Үүнийгээ бүрдүүлчхээд буцаагаад энэ арилжааны банкнууд байршуулахаараа хүү авдаггүй ийм байдал бас байгаа юм шиг байна. Тэгэхээр энэ дээр маш тодорхой ямар хэмжээний Засгийн газар болон төсвийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд байж байгаа. “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Монгол” гээд. Ямар хэмжээний мөнгө энэ арилжааны банкнууд дээр байршиж байгаа вэ. Маш тодорхой дүнтэй энийг хэлээч гэж хэлмээр байна.

2 сангийн үлдэгдэл гэхэд чинь 1,4 их наяд.../минут дуусав/

Д.Батбаяр: 3 асуултыг гурвууланг нь Сангийн сайд хариулчих уу. Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Ганзориг гишүүний асуултад хариулъя. Урсгал зардлын хэмжээ маргааши хэрвээ төсвийн тодотгол батлагдвал цаашидаа урсгал зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтэрч болохгүй гэдэг нэлээн ийм чанга ийм хязгаартай болно. Дээрээс нь Монгол Улсын нэгдсэн төсөв батлагдаад, үүнээс эдийн засаг руу орж байгаа 1 төгрөг бүр улсын эдийн засгийн хөгжлийн өсөлтийг дэмждэг. Тэгээд эдийн засгийн өсөлтөө дэмжихгүй байна гэдэгтэй бол бас санал нийлмээргүй байна. 2021 онд 36 их наяд байсан дотоодын нийт бүтээгдэхүүн, хойтон 95 их наяд болох гэж байна. Бараг 3 дахин

томорсон энэ дүн рүүгээ ойртож байгаа байхгүй юу. Тэгэхээр төсөв мөнгөний бодлого мөн хэрхэн яаж уялдаж эдийн засгийн өсөлтөө дэмжиж байгаа вэ гэдэг энэ тооноос бол харагдана.

Харин эдийн засгийн өсөлт яг иргэн бүрд хэрхэн яаж очиж байна вэ гэдэг бол дараагийн асуудал. Хамтарсан Засгийн газрын ерөөсөө Эрчтэй хөгжлийн төлөө зориг мөрийн хөтөлбөр маргааши батлагдана. Энэ бүхэн маань энэ эдийн засгийн өсөлтийг иргэн бүрд, айл өрх бүрд илүү их хүртээмжтэй ил тод байдлаар оруулах ийм зорилт тавин, мөн баялаг бүтээгчдийг, хувийн хэвшлийнхнийг, хөрөнгө оруулагч нарыгаа дэмжих тал руугаа илүү дэд бүтцээр дамжуулж, ингэж дэмжих хөгжих ийм загвар чиглэл нь ийм тодорхой болж ирнэ гэсэн үг.

Гацсан төслүүдийг хурдан дуусгамаар байна. Энэ дээр бол 100 хувь санал нийлж байна. Мөн тодотголоор дараагийн төсөв ч гэсэндээ гол бодлого энэ рүү яг чиглэнэ. Ялангуяа гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд тухайн жил зээлийн ашиглалтынх хязгаартаа баригдаад төслүүд маш их удааширдаг. Энэ дотор хамгийн том төсөл нефть боловсруулах үйлдвэр байна. Энийг үнэхээр 2026, 2027 он гэхэд ашиглалтад нь оруулчихмаар байна. Нээрээ л үнэхээр жилд бид гадагшаа төлж байгаа 1,5-2 тэрбум доллар, энэ жил бүр нэмэгдээд байгаа энэ нефть бүтээгдэхүүнд төлдөг төлбөр тодорхой хэмжээг нь Монголдоо авч үлдэх ийм л төсөл юм бол хурдхан шиг тэр үр өгөөжийг нь л хүртмээр байгаа юм. Ингээд зээлийн ашиглалтынхаа хязгаараас болоод бид жилдээ 100, 200 сая доллар л гаргадаг. Хойтонгоос төсөл өөрөө биднээс нэхэж байгаа нь бол 1 тэрбум доллар гаргаадхаач. Тэгвэл төслөө ингээд хугацаанд нь дуусгамаар байна гэдэг. Гэтэл ингэж гаргах нөгөө ашиглалтын хязгаартаа баригдаад ингээд болж өгөхгүй удаашираад байгаа юм. Тийм учраас энийг гишүүд маань их

сайн ойлгож, сайн дэмжиж байгаа учраас энэ томоохон төслүүдийг хугацаанд нь дуусгах зээл ашиглалтын үр өгөөжийг өндөр болгох тал дээр ингээд төсвийн шинэ бодлогууд явна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төслүүд дээр Ганзориг гишүүн ээ, нэг ийм болсон байгаа шүү. Төсвийн тухай хуулийн 29.3 дээр ийм юм байгаа юм. Өмнө нь бол ингээд ерөөсөө.../минут дуусав/

Д.Батбаяр: Дахиад 1 минут.

Б.Жавхлан: Баярлалаа. Өмнө нь бол юу гэдэг юм. Нөгөө 1 тэрбум төгрөгийн, 3 тэрбум төгрөгийн төсөл байлаа гэхэд энэ жил амсуулаад тавиад төсөл нь эхлүүлчихье гээд 100 сая төгрөг тавьдаг тийм он жилүүд их байсан. Энийг бол одоо хуулиар бүрэн зогсоосон. Ерөөсөө яг хамгийн цаад талын хугацааг 3 хуваагаад л яг тэнцүү 3 хуваагаад л цаад талын хугацаа 3 жилийн дотор ашиглалтад оруулна гээд ингээд тавьчихсан. Энэ ингээд их сайн зүйл болж байгаа. Тэгэхдээ үүний нөгөө талд бас нэг шинэ зовлон гарч ирж байгаа нь одоо ингээд төсөв өөрөө томроод, төсвөөр санхүүждэг төслүүдийн хэмжээ өртөг их том болж байна. Хэдэн 100 тэрбум болж ирж байна. Тэгээд 3 хуваагаад тавьчихад тэрийг даадаг аж ахуйн нэгжүүд тэрний шаардлагыг нь хангаж тендерт нь оролцдог аж ахуйн нэгжүүд маань байхгүй. Энд оролцож чадахгүй тийм аж ахуйн нэгжүүдээсээ ахадсан ийм том төслүүд хэрэгжиж эхлэхээр эргээд бас төсөл өөрөө эрсдэлд орох бас нэг дараагийн ийм зовлонгууд их гарч ирж байна. Тэгэхээр сүүлийн 2-3 жилийн хугацаанд батлагдсан төсвүүд дотор урт удаан хугацаанд хэрэгжих гээд эрсдэлд орсон тийм зүйлүүд бол харьцангуй бага байгаа.

Д.Батбаяр: Дахиад 1 минут.

Б.Жавхлан: Баярлалаа. Энэ талаар аудитынхан маань бас би үнэн ярьж

байна уу, худлаа ярьж байна уу нэг хэлээд өгвөл их сайн байна. Тэгээд тэр татварын орлого биелээд байгаа маань эдийн засаг маань нэлээн идэвхжээд, аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх чадвар нэмэгдээд, ер нь татварын суурь маань их сайн тэлж байгаа. Дээрээс нь татвар хураадаг энэ систем маань өөрөө их цахимжаад ойлгомжтой ил тод болж байгаа. Сүүлийн жилүүдэд энэ дээр нэлээдгүй шинэчлэл хийгдсэний үр дүнд энэ томоохон энэ татварын алба гэдэг чинь маш том систем шүү. 100 гаруй жилийн түүхтэй. Тэгэхээр эднийхээ ажлыг бас үнэлэх хэрэгтэй. Ажлын үр дүн нь ингэж болж ирж байна. Тэрнээс биш бүх аж ахуйн нэгжүүдийн дансыг нь хааж байгаад татвар авдаг гэсэн тийм нэг буруу ойлголт л явчхаад байх юм. Манайхан энэ дээр нэг статистик хэлээдхээрэй.

Дээрээс нь өнөөдөр би анх удаа ийм заал дүүрэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төлөөллүүд ирээд сууж байгааг би харж байна. Та нарт их баярлалаа. Дээрээс нь Байнгын хорооныхондоо их баярлалаа. Сайн зохион байгуулсан байна. Батбаяр даргад баярлалаа. Маш сайн идэвхтэй оролцсон байна. Тэгээд.../минут дуусав/

Д.Батбаяр: Ганзориг гишүүн тодруулга 1 минут.

П.Ганзориг: Би Монголбанкны төлөөллөөс бас яг энэ банктай холбоотой асуудлыг маш тодорхой асуумаар байна. Энэ Засгийн газар болон төсвийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд гээд цаанаа яг төсвийн мөнгө гэсэн үг. Үүний чөлөөт үлдэгдлүүд хэр үр ашигтай байришиж байгаа вэ гэдэг дээр маш тодорхой тоонууд хэлмээр байна л даа. 2 сангийн л дүн гэхэд 2023 оны чөлөөт үлдэгдэл 1.3, 1.4 их наяд байгаа байхгүй юу. Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан гээд. Тэгээд ер нь цаашидаа энэ төсвийн мөнгө байришиж байгаа, нөгөө талдаа банкнууд эрсдэл багатай гээд Засгийн газрын бонд

авчихдаг. Яг иргэд рүү чиглэсэн аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бизнесийн зээлүүд дээр болохоор хязгаарлалт тавьчихдаг. Мааш өндөр шалгуур тавьдаг. Тэгэхээр цаашидаа энэ баялаг бүтээж байгаа эдийн засаг дахь энэ хувийн хэвшлийн хувь хэмжээ оролцоог нэмэгдүүлэхийн тулд үүнийгээ бас энэ бодлогоор яаж уялдуулах вэ. Чөлөөт үлдэгдлүүдийнхээ үр ашгийг яаж сайжруулах вэ. Энэ дээр нэг тодорхой Монголбанкнаас хариулт өгөөч. Өчигдөр бас асуугаад тодорхой хариулт авч чадаагүй.

Д.Батбаяр: Энхтайван дарга. 5 номерын микрофон.

Д.Энхтайван: Ганзориг гишүүний асуултад хариулъя. Төсвийн ерөнхийлөн захирагчид болон төрийн өмчийн компаниудын чөлөөт мөнгөн үлдэгдлийг арилжааны банкнууд дээр хэрхэн байршуулж байгаа талаар бол гишүүн тодруулж байх шиг байна. Ер нь бол төсвийн ерөнхийлөн захирагч нар болон төрийн өмчийн компаниуд өөрсдөө дотоод дүрэм, журам, тухайн байгууллагад мөрдөгдөж байгаа тухайн процессыг зохицуулсан журмынхаа хүрээнд бол арилжааны банкнууд дээр бол мөнгөн үлдэгдлээ байршуулж явдаг. Яг одоогийн байдлаар бол Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын мөнгөн үлдэгдэл бол арилжааны банкнууд дээр байгаа. Нийгмийн даатгалын мөнгөн үлдэгдлийн хувьд бол 1 их наяд 494,2 тэрбум төгрөгийн мөнгөн үлдэгдэл арилжааны банкнууд дээр байна. Эрүүл мэндийн даатгалын хувьд 31,1 тэрбум төгрөгийн мөнгөн үлдэгдэл бол арилжааны банкнууд дээр байгаа. Ер нь бол бусад төрийн өмчийн томоохон аж ахуйн нэгжүүд, тэр дундаа “Эрдэнэс Тавантолгой” болон “Эрдэнэс Монгол” болон бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд бол хэдий хэмжээний мөнгөн үлдэгдэлтэй байгаа талаар бид бүхэнд мэдээлэл алга байна.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн төлөөлөл бол энд байх шиг байсан. Тэгэхээр тэр талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх байх. Ер нь бол Төв банкны зүгээс арилжааны банкнуудын дотоод үйл ажиллагаа болон тэр хүүгийн нөхцөл гэх мэтчилэн гадаад болон дотоод зах зээл дээрээс эх үүсвэр татаж байгаа үйл ажиллагаанд бол хөндлөнгөөс оролцдоггүй. Төв банк бол зөвхөн өөрийн мөнгөний бодлогынхоо хүрээнд нэгдсэн байдлаар мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээрээ дамжин зах зээлийг бол зохицуулж явдаг.

Д.Батбаяр: Дараагийнхаа асуултыг авчихъя даа. Батжаргал гишүүний асуулт.

Ж.Батжаргал: Та бүгдийнхээ энэ оройн амар амгаланг айлтгая. Тэгэхээр 2023 он бол ковидын дараах эдийн засгийн идэвхжилийн л он жил л дээ. Тэгээд ямар ч байсан төсвийн ил тод, нээлттэй байдал, хариуцлага, сахилгыг сайжруулах чиглэлээр гаргасан хууль тогтоомжуудын хэрэгжилт бас гайгүй үр дүнтэй байгаа юм уу л гэж хараад байгаа шүү дээ би бол. Төсвийн орлого бас амаргүй цаг хугацаанд давж биелсэн байна. Төрийн хэмнэлтийн хуулиа баримталж, төсвийн зарлага, санхүүжилт бас хэвийн түвшиндээ бас үл ялиг хэмнэлттэй гэмээр юм уу гарсан юм билээ. Тэгээд нэгдсэн төсвийн тэнцэл өөрөө ашигтай гарсан гээд бас эдийн засаг төсвийн үндсэн үзүүлэлтүүдэд бол нэлээн тийм гайгүй үр дүн гарсан. Тийм учраас энд бол яах аргагүй Засгийн газар энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар бол бас нэлээн хичээж ажиллажээ л гэж л ингэж л би бол дүгнэмээр байгаа.

Их хурал мэдээж гүйцэтгэлээ ярьж байна. Ярих ёстой. Бид бол батламжлах гээд байна. Их хурлын тогтоол 2 заалттай л ороод ирчихсэн байна лээ шүү дээ. Тэгвэл одоо энэ олон Байнгын хороод дээр яригдсан саналуудыг цаашид энэ төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад хэрхэн, яаж анхаарах юм бэ

гэдэг асуудал өөрөө чухал асуудал болж үлдэж байгаа юм. Тийм учраас Төсвийн зарлагын хяналтын дэд хороо байх юм уу, Төсвийн байнгын хороо байх юм уу. Энэ олон санал, дүгнэлтүүдийг нэгтгэж, ажлын төлөвлөгөө гэдэг юм уу, эсвэл тогтоол гаргаж ажиллавал энэ төсвийн сахилга хариуцлага энэ юманд нэлээн сайжрах бололцоо боломж бүрдэх болов уу гэсэн ажил төрлийн талаасаа нэг ийм зүйл байна гэж.

2 дахь зүйл орлого даваад биелдэг. Ирээдүй өв сангийн төлөвлөгдсөн орлого 100 гаруй тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн юм билээ. Тэрний учир шалтгаан нь юу юм бол гэж. 540 тэрбум төвлөрүүлнэ гэххэд 416.2 тэрбумыг билүү дээ төвлөрүүлсэн ийм дүн гарч ирж байгаа юм. Тэр нь эрх зүйтэйгээ холбоотой юм уу. Юутай холбоотой юм. Энийг нэг тодруулчихмаар байгаа юм гэж.

2 дахь зүйл гадаадын зээл тусламжийн хөрөнгийн санхүүжилт нь болохоор 80 хэдэн хувьтай. Ажлын бодит гүйцэтгэл нь 40 хэдэн хувьтай гэж гарч ирээд байгаа юм. Тэр нь бодвол ганц нэг томоохон төсөл арга хэмжээ дээр байгаа болов уу гэж бодоод байх юм. Энэ ер нь ямар учиртай ийм дүгнэлт, аудитын дүгнэлтэд орчихсон юм бэ гэдэг нэг ийм зүйл байна гэж.

Төсвийн байгууллагууд орон нутгийн болон төрийн өмчтэй аж ахуйнуудын өр, авлагын асуудал дээр анхаарал татаад байгаа юмнууд байна. Жишээ нь “Эрдэнэс Тавантолгой”-н авлага 500 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдсэн юм билээ. Энэ ямар учир шалтгаантай авлагууд байгаад байна. Дам дамаа энэ заяагдмал баялаг дээр тулгуурлагдчихсан, тэгээд ард түмний бас хувь хүртэх ёстой энэ компаниуд нэг иймэрхүү.../минут дуусав/

Д.Батбаяр: 1 минутыг нь өгчихье.

Ж.Батжаргал: Ажиглаад байхаар бид бас л жоохон эргэлзээ байгаад байна л даа. Тэгэхээр энэ ямар учир шалтгаантай авлага нэмэгдчих вэ гэж. Нөгөө талд өглөг дээр манай Эрүүл мэндийн даатгалын сан 150 хэдэн тэрбум төгрөгийн өглөг нэмэгдсэн харагдаад байгаа юм. Мэдээж ирсэн нэхэмжлэл юмнуудыг тодорхой хянаад баталгаажуулаад, өглөг талдаа тусгасан байж таарна. Гэтэл нөгөө талд нь нэгдсэн төсвийн тэнцлийн юмыг харахаар 10 хэдэн тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан тухай л ийм л дүн мэдээ гарч ирээд байгаа юм. Тэгээд энэ 2 үзүүлэлт хоорондоо яаж балансжиж, дүгнэлт гараад байна. Үүнийг би аудитын байгууллагаас тодруулах ёстой юм болов уу гэсэн ийм бодол байна.

Тэгээд цаашид аудитын байгууллагаас их тодорхой санал, дүгнэлтүүд ирчихсэн юм билээ. Их хурал, Засгийн газарт. Энэ төрийн өмчтэй компаниудынхаа эрх зүйн орчин юмнуудыг тодорхой болгох тухай.../минут дуусав/

Д.Батбаяр: 4 асуулт. 1 нь Сангийн яам. 2 нь Аудит, 1 Эрдэнэс Монгол хариулах нь байна. Сангийн яам эхлээд хариулах уу. Төрийн нарийн бичгийн дарга 3 номерын микрофон.

Ж.Ганбат: Сангийн яамнаас гадаад зээл тусламжийн гүйцэтгэл, санхүүжилттэй гээд асуулт асуулаа. Гадаад зээл тусламжаар 2023 онд хэрэгжсэн төслүүдийн нийт ажлын гүйцэтгэл 48 хувьтай байсныг аудитын тайланд 2023 онд батлагдсан санхүүжилтийн гүйцэтгэлээ харьцуулж ингээд бичсэн байна лээ. Бид бол төслүүдийн ажлын гүйцэтгэл санхүүжилттэй уялдаг. Сангийн яам дээр бол захиалагч нар гүйцэтгэлийг хянан баталгаажуулж ирээд, тэрнийх нь дагуу санхүүжилт хийгээд явж байгаа. Сүүлийн 3 жил бол гадаад зээлийн ашиглалтын санхүүжилт бол харьцангуй сайжирсан байгаа. Бид бол жилд

батлагдсан дүнгээр нь 100 хувийн санхүүжилт ажилтай нь уялдуулаад олгоод бол явж байгаа гэдэг ийм байдалтай байгаа.

Д.Батбаяр: Энэ ирээдүй өв сангийн 540 сая. Тэр нь 416 болчихсон байна гэсэн шүү дээ дарга аа.

Ж.Ганбат: Ирээдүй өвс санд төвлөрөх энийг би тоог нь тодруулаад хэлье. Уг нь Ирээдүй өв санд өнгөрсөн 2023 онд төвлөрөх ёстой орлого бол бүрэн төвлөрсөн байгаа. Яах зөрүүг нь гол ирээдүй өв санд орлого төвлөрүүлэгч байгууллагуудаар нь би гаргасан тоог нь эргээд танд нягтлаад хэлье.

Д.Батбаяр: Одоо Эрдэнэс Монголын төлөөлөл хариулах уу. “Эрдэнэс Тавантолгой” авлагын асуудлыг хариулчих: 1 номерын микрофоныг нь өгчих.

Х.Мөнхжаргал: Сайн байцаана уу. Гишүүний асуултад хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал. Авлагуудын хувьд бол “Эрдэнэс Тавантолгой” компани биржээр нүүрсээ арилжиж эхэлснээс хойш худалдан авагчтай 1 худалдан авагчтай байгуулсан гэрээг бол төлбөрийг 2-3 хувааж авдаг. Тэрэнтэй холбоотой аваагүй байгаа зарим авлагууд байгаа. Мөн Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу төмөр замын төслүүд байгаа. Тавантолгой түши байгаа. Тэр компаниудад өгөгдсөн санхүүжилттэй холбоотой бас урт хугацаат авлагууд 2023 ондоо нэмэгдэж бас тавигдсан байгаа. Тайлагнагдсан байгаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Аудитын байгууллага хариулах уу. Эрүүл мэндийн даатгалын сангийн өглөгийн тухай. 7 номерын микрофоныг нээе.

Я.Самбууням: Үндэсний Аудитын газар Самбууням байна. Батжаргал

гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл мөнгөн сууриар илэрхийлэгдэж байгаа учраас яг юунуудтайгаа бол тайлантайгаа бол зөрүүтэй байгаа. Санхүүгийн тайлан нь бол аккруэл сууриар тайлагнагдаж байгаа ийм зөрүү нь байгаа. Нөгөө ажлын гүйцэтгэлийн талаар гадаадын зээл тусламж олгогдсон 149 төслийг хэрэгжүүлэгч 19 төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөл хөтөлбөрүүдийн ажлын гүйцэтгэлийн дундаж 48,8 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 85,7 хувьтай байгаа. Энэ дээр бол Эдийн засаг, хөгжлийн сайд дээр 4 төсөл арга хэмжээ 97,6 хувийн гүйцэтгэлтэй. Эрчим хүчний сайдтай 17 төсөл 56,4 хувийн гүйцэтгэлтэй, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд дээр 5 төсөл 51,4 хувь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 12 төсөл 51 хувь, Нийслэлийн Засаг дарга 30 төсөл 51,3 хувьтай ийм тус тус хэрэгжилттэй байна.

Д.Батбаяр: Батжаргал гишүүн 1 минут.

Ж.Батжаргал: Би ойлгосон л доо энэ дотор биччихсэн байгаа юмнаас бол. Тэгээд харин яагаад ийм зөрүү гараад байна вэ гэдэг л асуудал байгаад байгаа байхгүй юу. Санхүүжилт, бодит ажил 2 яагаад ийм их хоорондоо зөрүүтэй байгаад байна вэ гэж. Үндсэндээ яг нарийндаа хэлэх юм бол хийгдээгүй ажилд санхүүжилт өгчихсөн болж харагдаад байгаа байхгүй юу наадах чинь. Тэгэхээр үүнийг та нар яагаад ийм байдлаар дүгнэлт хийчхэв гэдэг асуудал байна. Би бол тийм өндөр зөрүү хоорондоо гарна гэж нэг их ойлгохгүй л байгаад байна шүү дээ. Тэгэхээр үүнийг тодорхой болгож яах ёстой.

Дараагийн нэг зүйл нь би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг л анхаарах ёстой юм болов уу эсвэл Төсвийн байнгын хороо анхаарах ёстой юм уу. Тэр түрүүний ярьдаг байхгүй юу. Энэ

гүйцэтгэл ярьж байгаа юм дээр бид шийдвэрээ тов тодорхой стандартаараа гаргачихдаг. Цаашид анхаармаар байгаа юмнуудаа яаж бодлогын шийдэл болгож авч явах юм гэдэг л асуудал байгаад байгаа л даа. Олон Байнгын хороо өөр өөрийнхөө мэргэжлийн чиглэлээр ийм ийм зүйлүүдийг.../минут дуусав/

Д.Батбаяр: Аудитын газрын ахиад 7 номерын микрофон.

Я.Самбууням: Аудитын дүгнэлтээр бол бид санхүүжилтийг ажлын гүйцэтгэлийг нь хянахгүйгээр санхүүжилтийг нь тухай бүрд нь хуваарийнх нь дагуу олгоод явчхаж байгаа. Гэтэл ажил нь бол бүрэн хэмжээнд хэрэгжихгүй байгаагаас ингэж зөрүүтэй ойлголт үүсэж байна. Ажил, санхүүжилт хоёрынх нь хувь хэмжээ зөрүүтэй олгогдож байна гэж үзсэн. Баярлалаа.

Д.Батбаяр: Одоо Заяабал гишүүн. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би 2 байгууллагаас асууя. Төрийн аудитын газар болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуулт асуух гэж байгаа юм.

Тэгэхээр 1 дүгээрт энэ аудиттай холбоотой асуудал. Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1 дээр байгаа. Санхүү, гүйцэтгэлийн, нийцлийн ийм аудитыг хийж, жилийн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитыг хийж танилцуулж байгаа. Мааш том нүсэр ажил. Мааш их хүн цаг орсон мааш их нүсэр ажил. Энэ том ажлын үр дүн нь юу байх вэ гэвэл тухайн жилд бид нар хэрэгжүүлсэн төрийн бодлогын хэрэгжилт байгаа онож уу, тухайн жил төлөвлөсөн төрийн ажил бодлого нь зөв тодорхойлогдож уу, хүрэх ёстой үр дүндээ хүрч үү, тэрийг дараа жилд нь бид нар яаж өөрчлөх вэ, яаж сайжруулах вэ гэсэн ийм томоохон бодлогын асуудлууд энэ дээр яригдах ёстой л гэж би харж байгаа юм л даа. Тэр

гүйцэтгэлийн аудитын энэ удаагийнх бол ингээд хаврын чуулганаар хэлэлцэх ёстой байсан. Сонгуультай холбоотойгоор ингээд хоцорч орж ирж байгаа. Яах вэ дараа дараагийн жилүүд дээрээс хаврын чуулган дээр энэ нэлээн дэлгэрэнгүй яригдаад явах байх гэж бодож байна. Тэгэхээр энэ гүйцэтгэлийн аудитын энэ дүгнэлтүүдийг хэлэлцэж, хамгийн гол нь дараа жилд засварлах ёстой төрийн бодлогууд эндээс бол оновчтой тодорхойлогдох ёстой. Энэ тал дээрээ бол бас аудитын байгууллага маань бас онцгой анхаараарай гэдгийг хэлэх гэсэн юм. Ингээд би товчхон 2 асуулт асуучихъя. Ер нь бол Байнгын хороодын хуралдаан дээр орж байгаа гүйцэтгэлийн тайлан, мэдээллүүдийг бол сонсож байсан. Давхцахгүй байдлаар асуулт асууя.

1 дүгээрт нь уул уурхайн биржийн энэ тухай хууль 2023 онд гарсан. Засгийн газрын ч тогтоол шийдвэрүүд гарсан. Энэ дээр бол нүүрс, төмрийн хүдэр, жонши, зэс гэх мэтчилэн бүх л баялгуудыг уул уурхайн биржээр зарна гэдэг ийм асуудал ярьсан. Энэ бүх баялгуудаа бид нар уул уурхайн биржээр зарж чадаж байна уу. 1 дүгээрт.

2 дугаарт энэ одоогийн явж байгаа уул уурхайн биржийн чинь үйл ажиллагаа яг зөв явж чадаж байна уу. Дуудлага худалдаа хэлбэрээр явагдаад байгаа юм биш биз дээ. Дэлхийн биржийн яг үндсэн энэ хэлбэр лүүгээ орж чадсан юм уу. Үүнтэй холбоотой ирээдүйд алдаа оноо гарах вий дээ. Энэ дээр танай байгууллагын зүгээс харж байгаа аудитын үнэлэлт дүгнэлт нь юу байна вэ гэдэг талаас 1 дүгээрт асуух гэсэн юм.

2 дугаарт нь 2023 оны төрийн байгууллагын аудитыг хийсний үр дүн дээр энэ төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт ер нь хэр оновчтой байгаа юм бэ. Зарим газрууд дээр алдагдаж байгаа чиг үүрэг, зарим газрууд дээр давхцаж байгаа чиг үүрэг, эсвэл чиг үүргүүдийг нь нийлүүлээд нэг

газраа бөөгнүүлчихвэл бас үр дүн, хэрэгжилт нь сайжрахуйц ийм дүгнэлтүүд байна уу гэдэг ийм 2 асуултыг танайхаас асуух гэж байгаа юм.

2 дугаарт нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бас 2 асуулт асуучихъя. Би минутаа аваад явчихъя. Дэд хорооны дарга аа. Тэгэхээр танай байгууллага бол энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд ирүүлж байна л даа. Энэ дээрээ бол ийм 2 дүгнэлт тавьчихсан байгаа юм. Зарлагын өсөлт 2023 оны зарлагын өсөлт төлөвлөснөөсөө гүйцэтгэл нь өслөө гэдэг ийм дүн гаргаж ирж байгаа. Нөгөө эрдэс баялгийн бус бүтээгдэхүүнүүдийн дундаж үнээр тодорхойлогдох ёстой 2023 оны 3 байтал 2023 оны 9 болоод ингээд төсвийн зарлагын юу нь бол өсчихжээ гэдэг ийм дүгнэлт 1 дүгээрт гаргасан байгаа. 2 дугаарт нь энэ төсвийн орлого төлөвлөлт алдаатай байна. Энэ алдаатай төлөвлөлтөөс болоод энэ зарлага нь бас хэтрэх асуудал нь үүнтэй бас холбоотой байна гэсэн ийм дүгнэлт хийчихсэн байна л даа. 2023 оны хувьд бол танай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ дээр арай байгаагүй байх. Одоо бол танайх бол үйл ажиллагаа чинь яваад эхэлчихсэн байгаа. Одоо бол төсвийн төлөвлөлт бол танай гаргаж өгсөн макро эдийн засгийн үзүүлэлтээр үндэслэж, төсвийн төлөвлөлтүүд явж байгаа. Тэгэхээр цаашдаа ийм асуудал гаргахгүй байж болох уу. Та нар энэ дээр ямар бодолтой байгаа вэ. Бодлого барьж байгаа гэдэг талаараа хариулт өгөөч гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Батбаяр: Аудит. 7 номерын микрофон.

Я.Самбууням: Үндэсний аудитын газар Самбууням байна. Заяабал гишүүний асуултад хариулъя. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт төрийн өмчит компанийн үйл

ажиллагааг ил тод болгох бодлогын хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг боловсруулж, батлуулсан байгаа. Үүний хүрээнд бол Засгийн газрын биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай 2023 оны 223 дугаар тогтоолоор хайлуур, жонш, төмөр, нүүрсийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалахаар шийдвэрлэсэн байдаг. Тэгээд 2023 оны байдлаар бол 299 арилжаагаар 15,6 сая тонн бүтээгдэхүүнийг борлуулсан. Үүний 95,7 хувь нь нүүрс, 4,3 хувийг төмрийн баяжмал эзэлсэн байдаг. Энэ нь бол бас Байнгын хороо дээр гишүүд асууж байсан. Яагаад энэ зэс, зэсийн баяжмалыг биржээр арилжуулахгүй байгаа юм бэ гэдэг асуудал. Энийг бол арилжаалахаар төлөвлөж ажиллаж байгаа гэдгийг бол холбогдох төсвийн захирагч нар бол хэлж байсан.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа тогтолцооны хувьд бол манайх бол төрийн байгууллагуудын хүний нөөц, тогтолцооны аудитыг энэ жил Төсвийн байнгын хорооны захиалгатайгаар сэдэв баталж өгсөн сэдвийн хүрээнд бол энэ аудитыг хийх гэж байгаа. Аудитын тайланг бол бид Төсвийн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцүүлнэ. Энэ үед танд тайланг жичид нь хүргүүлье. Баярлалаа.

Д.Батбаяр: Тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаяр дарга. 5 номерын микрофон дээр байна. 5 номерыг нээчихье.

Н.Энхбаяр: Эрхэм гишүүд болон оролцож байгаа хүмүүс та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн Заяабал гишүүний тавьсан 2 асуултад хариулъя. Хуульд заасны дагуу бид Төсвийн тогтвортой байдлын хуульд заасны дагуу Монгол Улсын 2023 оны гүйцэтгэл болон нэгдсэн төсвийн тайлангийн талаар бол дүгнэлтээ гаргаад Төсвийн байнгын

хороонд хүргүүлсэн. Энэ дүгнэлт дотор төсвийн тусгай шаардлага хангасан эсэх талаар бид нар бас тодорхой эх үүсвэрүүдийг ашиглаад статистикийн болон бусад эх үүсвэр дээр үндэслээд тооцооллоо хийгээд, ингээд дүгнэлтээ өгсөн байгаа. Эрхэм гишүүд та бүхэнд бол тараагдсан байх.

Магадгүй энэ 2 шалгуур болон гүйцэтгэл үзүүлэлтийн зөрүү чухам яагаад зөрүүтэй байгаа вэ гэдэг дээр илүү яг эх үүсвэр нь яг зөв эх үүсвэрүүд ашиглагдсан уу үгүй юу. Мэдээж эх үүсвэр зөрүүтэй байдал байсан ч байж болно. Энийг дахин илүү нарийвчлан шалгаж, дүгнэлтээ гаргах байх гэж найдаж байна. Бид нар ямар ч байсан өөрийнхөө хэмжээнд байгаа эх үүсвэр дээрээ тооцоолол хийгээд дүгнэлтээ өгчхөөд байгаа.

2 дахь асуудлын тухайд төлөвлөлтийн алдаа гарч байгаа тухай энэ бол анх удаа ярьж байгаа биш. Мэдээж өнгөрсөн жилүүдийн төсвийн гүйцэтгэл ярихдаа Улсын Их Хурал дээр энэ тухай байнга яригдаж байсан. Улсын Их Хурлаас төсвийн гүйцэтгэл хэлэлцээд удаа дараа гаргаж байсан тогтоолууд дээр ч гэсэн энэ тухай дурдагдсан байдаг. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өнгөрсөн онд орсон өөрчлөлтийн дагуу 1 шинэ гүйцэтгэж байгаа үүрэг бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад үндэслэх макро эдийн засгийн тооцооллыг бид гаргаж байгаа. Өнгөрсөн хавар 3 дугаар сарын эхээр энэ тооцооллоо гаргаад Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ дотор дурдагдсан бидний дурдсан орлого, зарлагын хязгаар байгаа. Харамсалтай нь одоогоор сүүлийн өдрүүдэд хэлэлцэгдэж байгаа энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарт бол энэ бол удаа дараа энэ хязгаарууд зөрчигдөөд явж байна. Тэгэхээр ийм байдлаар хэрвээ цаашидаа энэ яг хуульд тусгагдсанчлан төсвийн

хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн энэ тооцоолол дээр үндэслэдэг бол илүү оновчтой болох болов уу гэсэн бидний байр суурь байгаа. Одоо бол зүгээр хүргүүлнэ. Энийг үндэслэнэ л гэсэн байгаа. Тэгээд яг гол нь энэ дээр бид нар араас нь энийгээ хяналт тавих чиг үүрэг бол бид нарт хараахан байхгүй байгаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Заяабал гишүүний тодруулга.

Б.Заяабал: Тэгэхээр Энхбаяр дарга аа, энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу танай зөвлөл байгуулагдсан. Бас энэ Улсын Их Хурал төсөв дээр бас хяналт тавих тогтвортой байлгах хамгийн чухал үүрэг нь танай байгууллага дээр байгаа. Тэгээд танайх энэ тооцоо судалгаа хийхдээ эх үүсвэрүүдийгээ нэг болгох чиглэл дээр цаашидаа анхаар. Ингээд ийм эх үүсвэр нь өөр байж магадгүй гэдэг ийм байдлаар хариулт хэлэх нь буруу байна. Энэ төрийн энэ бас том бодлогын асуудал яригдаж байгаа учраас та бүхэн энэ дээрээ онцгой анхаарах ёстой.

2 дугаарт тэр төсвийн макро эдийн засгийн үзүүлэлтээр үндэслэж төсөв боловсруулагдах ёстой. Энэ бодлогыгоо бол манай Засгийн газар ч гэсэн цаашидаа бас анхаарч, 1 тоотой явах нь зөв байх гэж бодож байна.

2 дугаарт нь тэр аудитын газар, тэр биржтэй холбоотой тэр уул уурхайн бирж чинь зөв явж байгаа юм уу. Энэ олон улсын уул уурхайн биржийн явдаг зарчмаараа явж чадаж байгаа юм уу гэдэг дээр хариулт өгсөнгүй. Энэ дээр бас хариулт авъя.

Мөн энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарт хэлэхэд төсөв боловсруулахдаа зорилтот арга хэмжээ, тэрийг шалгадаг шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөв боловсруулагддаг. Ингээд

энэ шалгуур үзүүлэлтийг хангахын тулд төсөв боловсруулагдаж.../минут дуусав/

Д.Батбаяр: 7 номерын микрофон.

Я.Самбууням: Энэ биржсийн арилжаа явагдаад удаагүй байгаа. Тэгэхээр энэ 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар энэ биржээр уул уурхайн бүтээгдэхүүн арилжиж байгаа төрийн өмчит аж ахуйн нэгжийн аудитыг хийхдээ биржээр хэрхэн борлуулалтыг хийж байгаа талаарх нийцлийн аудитыг хийж тайландаа тусгана. Одоохондоо бол бид энэ дээр тусгайлсан аудит хийгээгүй байна.

Д.Батбаяр: Одоо Баясгалан гишүүний асуулт.

Ж.Баясгалан: Ийм олон ажлын хэсгийн гишүүдтэй ерөөсөө уулзалдаагүй юм байна. Тэгэхээр ирсэн бүх хүмүүстээ баярлалаа. Тэгээд 3 асуулт байна.

1 дүгээрт Эрүүл мэндийн сайдын эрхлэх байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар 83,5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байсан. Дээд шатны төсвийн захирагчаас үнэ төлбөргүй хуваарилсан 1,3 тэрбум, тэгээд дээр нь болохоор харьяа төсвийн байгууллагууд данс бүртгэлдээ тусгагдаагүй 5 байгууллагын 1,3 тэрбум, өмнөх онуудад харьяа байгууллагуудад хуваарилсан 18,8 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад эргэлтийн хөрөнгө данснаас хасаагүй. Давхар бүртгэгчид байсан лээ. Тэгээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бас өмнөх онуудад хийгдсэн, Улсын комисс хүлээж авсан 2,8 тэрбум төгрөгийн барилга, 2,5 тэрбум төгрөгийн их засварын ажлуудыг ашиглагч байгууллагуудад нь шилжүүлээгүй ийм зөрчил гарсан байсан. 1 дүгээрт энийг тайлбарлаад өгөөрэй.

2 дугаарт нь 2023 оны улсын төсвийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ

хэлж байх үедээ 2023 оноос хөдөлмөрийн бүтээмжид суурилсан төрийн албаны цалингийн тогтолцоог нэвтрүүлнэ гэсэн. Тэгээд төрийн жинхэнэ албан хаагчийн 160 гаруй цалингийн шатлалыг 20 болгон бууруулна. Олон улсын жишигт нийцүүлнэ гэж хэлсэн. Төрийн албан хаагчийн цалингийн тогтолцоо шинэчлэх талаар ямар ажил хийсэн бэ. Энэ 160 гаруй цалингийн тогтолцоог 20 болгож буулгаж чадсан уу. Энэ олон улсын жишигт нийлүүлж чадсан уу гэж Жавхлан сайдаас асууя.

Бас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд дулаан, цахилгаан үйлдвэрлэх шинэ төслийг орлого олж эхэлсний дараагийн жилээс эхлэн 3 жилд 90 хувиар, дараагийн 3 жилд 50 хувиар татварын хөнгөлөлт үзүүлнэ. Нийслэл хотоос орон нутагт агуулахаа нүүлгэсэн, орон нутагт шинээр үл хөдлөх хөрөнгө бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн аж ахуйн нэгжид татварын дэмжлэг үзүүлнэ гэсэн. Тэгэхээр дулаан, цахилгаан үйлдвэрлэх хэдэн шинэ төсөл хэрэгжүүлсэн бэ. Улаанбаатар хотоос орон нутагт үйлдвэр агуулахаа нүүлгэсэн, орон нутагт шинээр үл хөдлөх бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн хэчнээн аж ахуйд хэчнээн хэмжээний татварын дэмжлэг үзүүлсэн бэ гэдэг дээр тодорхой хариулт хэлээд өгөөрэй.

Д.Батбаяр: Эрүүл мэндийн яамнаас хүн байхгүй. Сангийн сайд хариулах уу. 5 номерын микрофон дээр. Албан тушаалаа хэлээд, нэрээ хэлээрэй. Аудитын тайлантай холбоотой асуулт байна.

Л.Лувсан: Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Лувсан. Гишүүний асуултад хариулъя. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 89,8 тэрбум төгрөгийн алдаа гарсан байгаа. Энэ болохоор Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд баригдаж, 2019 он ашиглалтад орсон Сонгинохайрхан

дүүргийн нэгдсэн эмнэлгийн 88,9 тэрбум төгрөгийн үнэтэй барилгыг орлогод авч бүртгэснийг Эрүүл мэндийн яамны бусад эргэлтийн хөрөнгө дансанд давхар бүртгэсэн гэсэн зөрчил байгаа. Он дамжиж хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ яамны дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй байсныг 2019 оноос 2022 он хүртэл давхар бүртгэж авсан алдаа байсныг 2023 онд залруулсан байгаа. Дээд шатны байгууллагаас харьяа 5 төсвийн байгууллагад данс бүртгэлдээ тусгаагүй шилжүүлсэн хөрөнгийг тусгаагүй гэсэн зөрчил илэрсэн. Эрүүл мэндийн сайдын тушаалаар харьяа орон нутгийн байгууллагуудад шилжүүлсэн хөрөнгө тухайн аймагтаа бол данс бүртгэл тусгаадаагүй байсныг орон нутгийн аудитын байгууллагаас бас илрүүлж гаргаж ирсэн ийм зөрчил байгаа. Үүнийг бас тайлангийн явцад залруулаад данс бүртгэлд авсан байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн улсын комисс хүлээж авсан боловч данс бүртгэл тусгаагүй гээд бас 5,3 тэрбум төгрөгийн зөрчил үүссэн. Энэ асуудлыг болохоор манай яамнаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан тоотоор хүргүүлчихсэн, шийдвэр хараахан гараагүй байсан учраас орлогод авагдаагүй. 2024 оны 1 сард бол нөхөөд орлогод авсан байна.

Өмнөх онуудад харьяа байгууллагуудад хуваарилсан 18,8 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад эргэлтийн хөрөнгө данснаас хасаагүй, давхар бүртгэгдсэн гэсэн 18,8 тэрбум төгрөгийн зөрчил байсан. Үүнийг болохоор бас тухайн үед ковидын нөхцөл байдалд, бас тухайн үеийн санхүү бүртгэлийн ажилтнууд орон нутагт хуваарилагдсан хөрөнгийг дуусаагүй үйлдвэрлэлийн данснаас хасагдаагүй тийм зөрчил байсан байна лээ. 2024 оны 3 сард бас энэ зөрчлийг арилгасан байна. Баярлалаа.

Д.Батбаяр: Дараагийнх нь асуултыг асуусных нь дараа тодруулга авахаар бол авъя. Сангийн яам 4 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Цалингийн бодлогын хувьд бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан бас нэмж хариулах байх. Засгийн газрын хувьд барьж байгаа бодлого гэх юм бол төрийн үйлчилгээний албыг бол тусад нь гаргаад, энэ хэсэг дээр бол бид нар илүү бүтээмжид суурилсан хэн илүү сайн ажиллаж чадаж байна тэр нь илүү их цалин авах бол боломжийг нээх ийм бодлого бол баримтлаад явж байгаа. Энэ дагуу бол Засгийн газраас боловсрол, эрүүл мэндийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилт бол бид нар ингээд шилжүүлчихсэн юм. Энэ дагуугаа төрийн албаны тухай хуульд мөн өөрчлөлт оруулаад, цалингийн сүлжээг хатуу барихгүйгээр энэ сүлжээ нь бол доод хэмжээ байна гэж заачхаад байгаа юм. Энэ нь бол үүнээсээ бол дээшээ цалин авах боломжийг бол нээж өгч байгаа. Нөгөө талдаа бол энийг нь бүтээмжийн дагуу хийсэн бүтээмжээр нь бол цалингаа нэмэгдүүлэх боломжийг нь бас бид нар гаргаж өгөөд ингээд явж байгаа.

Д.Батбаяр: Жавхлан сайдын микрофоныг нээе.

Б.Жавхлан: Баясгалан гишүүний асуултад нэмж хариулъя. Засгийн газрын төрийн албан хаагчдын цалингийн бодлого бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн суурь бодлогуудын нэг. Сангийн яам Төрийн сан ямар үүрэгтэй вэ гэхээр тэндээс гарч ирсэн цалинг бол бүрэн санхүүжүүлэх ийм л үүрэгтэй явдаг юм. Тэгээд яах вэ сүүлийн жилүүдэд сая манай Санжаадорж дарга хэллээ. 2021 оноос эхлээд хамгийн анх эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилтэд орсон гэсэн үг. Одоо бүх бүтээгдэхүүнүүд нь

тарифтай болсон. Эмнэлэг дээр очиход тариф үйлчилгээ гээд. Тэндээсээ яг Засгийн газраас тогтоосон цалингийн суурь цалин дээр нь яг хийснээрээ авдаг болоод ингээд шилжсэн байгаа. Араас нь Боловсролын салбар орсон. Одоо 2, 3 дахь жилдээ явж байна. Мөн ноднингоос эхлээд соёлын салбар, биеийн тамир, спортын салбар гээд ер нь бүх салбарууд ингээд шат дараатай орж байгаа. Төрийн албан хаагч нар багтдаг нийтлэг үйлчилгээний албан хаагчдыг олон улсын.../минут дуусав/

Д.Батбаяр: Дахиад 1 минут Сангийн сайдад.

Б.Жавхлан: Олон улсын жишиг стандарт нь бол яг л нөгөө үйлчилгээ худалдаж авах буюу яг төрийн албан хаагч бол биш. Тэндээс яг нөгөө цэвэрлэгээ, харуул хамгаалалт гээд энэ бүгд дээр үйлчилгээгээ тарифжуулаад, гаднаас үйлчилгээ худалдаж авдаг хэлбэрээр энэ рүү шилжсэн байдаг юм. Яах вэ, бид 1 удаа энэ рүүгээ шилжих гээд 2022 онд нэг удаа үзсэн. Тэгээд оролдлого нэг сайн бүтэлтэй болж өгөөгүй. Тэгээд яах вэ, энэ 4 жил бас энэ тал руугаа шилжинэ гээд, ялангуяа манай Боловсролын яамнаас бас энэ санаачилгыг гаргаад, ирэх жилээс бол бүтэн шилжихгүй байх. Гэхдээ ингээд аажим аажмаар нийгэм энийг яаж хүлээж авах нь вэ, бэлэн байна уу, үгүй юу гээд судалгаа дээр үндэслэж байгаад ер нь явах байх.

Д.Батбаяр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга байгаа тээ. Энэ нөгөө ажлын байр нэмэгдүүлэх талаар татварын ямар бодлого гээд бас асуусан байгаа шүү дээ. Цалинтай холбоотой. Ямар татварын бодлого хэрэгжүүлж байна вэ гэж асуугаад байна шүү дээ. Эсвэл Баясгалан гишүүн ахиад тодруулж асуугаад, тэгээд ахиад асуучих уу. Баясгалан гишүүний микрофоныг өгчих. Тэр сүүлийн асуулт.

Ж.Баясгалан: 2 дахь асуулт дээр би хэлсэн шүү. Сая Жавхлан сайд хэлээд байна. 160 тогтолцоог 20 болгож чадсан уу. Стандартад нийцүүлж чадсан уу л гэж асуугаад байгаа. Тэгэхээр одоо хийж байгаа юм уу, эсвэл ерөөсөө өөрчлөөгүй байгаа юм уу. Энэ талаараа тодруулаад өгөөч. Хэд болсон юм бэ. 160-аас хэд болсон юм.

Д.Батбаяр: Энэ Мөнхзул дарга ирээгүй байсан билүү. Тодруулга юм уу. Дуусчихсан юм уу цаг нь. 1 минутыг нь өгчихье.

Ж.Баясгалан: Би ингээд юм асуухаар ерөөсөө хариулах хүн нь байхгүй болчихож байгаа юм уу. Эсвэл яг тодорхой хариулаад өгөх л хүн байвал хамаагүй. Энэ эргээд цаасаар өгчхөж болно. Гэхдээ гол нь яг энэ олон ажлын хэсгээс хүмүүс ороод ирчихсэн байж байж энд хариулах боловсон хүчин байхгүй байгаад нь маш их гайхаж байна. Яагаад энэ яамаа төлөөлөөд хүрээд ирж болдоггүй юм бэ. Өнөөдөр чинь төсөв хэлэлцэж байгаа бид нарын хамгийн сүүлийн л өдөр шүү дээ. Маргааш Их Хуралд орохоос өмнө энэ дээрээ анхаараад өгөөч ээ дарга аа. Энэ хүмүүсийг нь дуудаад яг гүйцэд хариултаа авмаар байна.

Д.Батбаяр: Тэгвэл дуудъя даа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төлөөлөл сайд эсвэл Төрийн нарийныг нь дуудъя. Хүлээж байя даа. Тэр хооронд нь ахиад энэ татварын хөнгөлөлтийн талаар Сангийн яамнаас хариулж байх уу. Ажлын байрыг нэмэгдүүлэх талаар татвар ямар бодлого баримталж байгаа вэ гээд 4 номер уу. 5 номерын микрофоныг нээе.

Р.Мягмаржав: Татварын ерөнхий газрын Татвар хураалт удирдлага, арга зүйн газрын дарга Мягмаржав. Баясгалан гишүүний асуултад хариулъя.

Татварын байгууллагаас ерөнхийдөө хуулиар олгогдсон татвар

төлөгчид олгогдож байгаа татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг бол хуульд заасан тайлангаар бол эдлүүлээд явж байгаа. Өнгөрсөн 2023 оны хувьд аж ахуйн нэгжүүдийг бол татварын шинэ хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд төлсөн татварынх нь 90 хувийг нь буцаан олгох хууль маань хуулийн хүрээнд нийтдээ 3865 татвар төлөгч маань 68,6 тэрбум төгрөгийг бол буцаан олгож яг авсан байгаа. Илүү төлөлттэй болоод алслагдсан бүс буюу Улаанбаатар хотоос 500-аас дээшээ 1 мянган километрийн зайтай байгаа тохиолдолд 50-90 хувийн хөнгөлөлт эдэлж байгаа. Энэ хүрээнд бол хөнгөлөлтөд нийтдээ 102 татвар төлөгч маань 4,6 тэрбум төгрөгийн буцаан олголтыг авсан байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хөнгөлөлтийг бол нийтдээ 1 татвар төлөгч маань 18 сая төгрөгийн хөнгөлөлтийг.../минут дуусав/

Д.Батбаяр: 5 номерын микрофоны дахиад нээчихье.

Р.Мягмаржав: Аялал жуулчлалын тухай хуультай холбоотойгоор бас аялал жуулчлалын салбарыг дэмжих зорилгоор бас хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлж байгаа. Үүндээ бол өнгөрсөн 2023 онд 3 татвар төлөгч маань 23 сая төгрөгийн буцаан олголтыг авсан. Тэгээд нийт дүнгээрээ бол 4111 татвар төлөгчид бол төсвөөс 75,9 тэрбум төгрөгийг бол буцаан олгосон. Энэ дээрх буцаан олголт, хөнгөлөлтийн маань үр дүн бол өөрөө тухайн салбарыг дэмжих, дээрээс нь ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжээд үр дүн нь гарсан байна. Баярлалаа.

Д.Батбаяр: 5 номерын микрофон дээр суучих. Санжаа дарга асуултыг нь дахиад хэлээд өгчих.

Б.Алимаа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн газрын дарга Алимаа асуултад хариулъя.

Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, ангилал зэрэглэлийг нягтаршуулах, үр дүн, гүйцэтгэлд чиглэсэн урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх үе шаттай арга хэмжээ авч байгаа. 2022 оноос 3 сарын 9-ний 107 дугаар тогтоолоор цалингийн шатлалыг өөрчилсөн. Одоогоор бол нийтдээ 295 ялгаатай цалингийн систем байсан. Энэ бол нягтаршаад нийтдээ 59 зэрэглэлтэй цалингийн систем болгож илүү хялбаршуулж, нягтруулсан. Цаашидаа бол төрийн албан хаагчдын нийтлэг үйлчилгээ, төрийн захиргааны албан хаагчид, төрийн тусгай албан хаагчдын ангилал зэрэглэлийг дахин шинэчлэх, шинээр гарч ирж байгаа ажил мэргэжлийн онцлогтой нийцүүлэх, түүнээс гадна үр дүн.../минут дуусав/

Д.Батбаяр: Дахиад 1 минутыг нь өгчихье. 5 номер.

Б.Алимаа: Үр дүн, гүйцэтгэлийн урамшууллыг нэвтрүүлэх зэрэг шат дараалсан арга хэмжээг бас төлөвлөөд Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны төлөвлөгөөнд оруулж тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Түүнээс гадна төрийн албан хаагчдын эрх зүйн статусыг ер нь төрийн үйлчилгээний болоод төрийн жинхэнэ албан хаагчдын хувьд бас ялгаатай тогтоох ийм шаардлага бас байгаа. Түүнээс гадна Засгийн газраас төрийн албан хаагчийн нийгмийн баталгаагаа, хүний хөгжил, нийгмийн хамгаалалттай холбоотой хуулийн төслийг бас шинээр боловсруулж оруулж ирэхээр бэлтгэж байгаа.

Д.Батбаяр: Одоо Цогтбаатар гишүүний микрофоныг нээе.

Дав.Цогтбаатар: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан саналтай бол санал нэг байгаа. Засгийн газарт тодорхой үүрэг чиглэл, даалгавар өгөх гэдэгтэй холбоотой. Тэгээд үүнтэй холбогдуулаад асуухад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 1 асуулт

байгаа юм. 6726 компани 51,5 их наяд төгрөг дотоодын нийт бүтээгдэхүүний 77,9 хувь. Энэ том дүн дээр хязгаарлалттай дүгнэлт аваад байгаа бид нар. Тэгээд энэ менежмент муу байна гэж би бол харж байна. Тэгээд үүнтэй санал нэг байна уу гэж. Тэгээд санал нэг байгаа бол энийг хувьчлаад юм уу, нэгтгээд юм уу сайжруулах тал дээр ямар бодлого байгаа вэ гэж 1 асуулт. Тэгээд энэ дээр жишээлээд ярихад бол Төрийн банк байгаа. Төрийн банкны 94,3 хувийг Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорац эзэмшээд явж байгаа. Асуудлууд нь яг хэвээрээ байгаа. Асуудал гэдэг нь ХДК ч юм уу Монголбанкных нь асуудлууд. Тэгээд би Гүйцэтгэх захирлаас нь асуух гээд байгаа юм. Таны гүйцэтгэх захирлаар томилогдохдоо анх ажилд очиж байсан амбиц ямар байсан бэ. Үр дүнд хүрсэн үү. Хүрсэн, хүрээгүйгээс дараагийн таны амбиц юу байна гэдэг дээр хариулт хэлж өгөөч ээ гэж.

Дараагийн асуулт Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг яагаад Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банканд байршуулах шийдвэр гаргасан юм бол. Энийг хэн шийдвэр гаргасан юм бол гэдгийг Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийнхан байвал хариулж өгөөч гэж байгаа юм. Тэгээд энэ мөнгөө алдчихаад байхад бид нар ямар нэгэн хариуцлага хүлээсэн хүн байгаа юу. Тэгээд энэ Хууль зүйн яамыг бол одоо би яг хэн араас нь явах ёстойг мэдэхгүй байна. Хууль зүйн яам жишээлэхэд үүний араас ороод явахад бол олсны үзүүрийг хөөгөөд явахаар үхэр байдаг гэдэг. Тэгээд үүний араас явахад бол бас нэг учир зүй нь олдох байх л гэж найдаад байгаа юм. Тийм учраас энэ дээр хариуцлагынх нь талаар мэдээлэл байвал өгөөч гэж байгаа юм.

3 дугаарт нь Монголбанкнаас Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр Монголбанк дорвитой арга хэмжээ аваад, дараа

дараагийн шатын арга хэмжээ аваад яваад байж болдоггүй юм уу. Илүү идэвхтэй ажиллаж болдоггүй юм уу гэж асууж байгаа юм.

Д.Батбаяр: Тэр 3 номерын микрофон дээр очоод сууцгаачих. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар.

Ц.Баяр-Эрдэнэ: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Баяр-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Монгол Улсад төрийн болон орон нутгийн өмчит төсвийн эх үүсвэрээр санхүүждэг 7 мянга орчим байгууллага байгаа. Эдгээрээс үндсэндээ 270 орчим орон нутгийн өмчит компани, 130 орчим төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компани нь үйл ажиллагаа явуулж байгаа. Төрийн өмчит 130-аад компани бол энэ жилийн хувьд жишээ нь 2023 оны гүйцэтгэлээр 5 их наяд орчим төгрөгийн төсөвт орлого төвлөрүүлсэн. 2 их наяд гаруй төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Гэхдээ энэ 100 гаруй компанийн одоо “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт” гээд 5, 6 компани нийт эдийн засгийн үзүүлэлтүүдийнх нь 90 орчим хувийг бол хангадаг. Бусад компаниуд бол эрчим, зам, тээвэр, бусад төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа жижиг компаниуд байдаг. Цаашид бол ер нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Монгол Улсын Засгийн газраас энэ төрийн өмчит компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх, томоохон компаниудыг нээлттэй компани болгож IPO гаргаж, хөрөнгийн бирж дээр олон нийтийн болгох энэ бодлогыг баримталж ажиллаж байгаа. Энэ хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн анхдагч хуулийн төсөл боловсруулагдаад бас Их Хурлын түвшинд ажлын хэсэг байгуулагдаад ажиллаад явж байгаа. Төрийн өмчит компаниуд бол сүүлийн 2020 оноос хойших үзүүлэлтүүдээр бол эдийн засгийн үзүүлэлтүүд нь харьцангуй сайжирсан. Гэхдээ зарим нэг ажил,

үйлчилгээг бол хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх ийм хэрэгцээ шаардлага байгаа гэж харж байгаа.

Д.Батбаяр: Төрийн банкны дарга Гантөр. 3 номерын микрофон.

Ө.Гантөр: Төрийн банкны гүйцэтгэх захирал Гантөр.Гишүүний асуултад хариулъя. Төрийн банк нь анх үүсгэн байгуулагдахдаа бол 147 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй үйл ажиллагаа эхэлж байсан. Би бол 2020 онд томилогдсон. Гүйцэтгэх захирлаар. Намайг ажил авахад бол актив хөрөнгө бол нийтдээ 3,5 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй байсан. Өнөөдрийн байдлаар бол 5,5 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй ингээд үйл ажиллагаа явуулж байна. Ашигийн хувьд бол 2020 оны эцсийн байдлаар 30,6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан. 2023 оны эцсийн байдлаар 94,7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын ажлыг авсан хугацаанаас хойш бол нийтдээ 288 тэрбум төгрөгийн ашигийг бол хийсэн байгаа. Мөн нийт хувьцааны 49 хувь нь Сангийн яам, 45 хувь нь бол Хадгаламжийн даатгалын корпорац, үлдээж байгаа 5,71 хувь нь бол олон нийтэд одоо ингээд харьяалагдаж байгаа. Нийтдээ бол 8 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй ийм байгууллага байгаа. 2022 оны ноогдол ашигийг бол бид бүхэн бүрэн хуваарилж өгсөн байгаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Бямбасүрэн дарга. 5 номерын микрофон. Эрүүл мэндийн даатгалын газар.

Ц.Ганцэцэг: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа Ганцэцэг байна. Гишүүний асуултад хариулъя. Чингис хаан банканд 2007 оноос, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд 2014 оноос байршуулж эхэлсэн. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг.

Тухайн үедээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэр гараад энэ ажил бол хийгдэж байсан.

Д.Батбаяр: Цогтбаатар гишүүн дахиад тодруулга асуулт асуух уу. Монголбанкны төлөөлөл Энхтайван дарга. 3 номер дээр суучих. 3 номерын микрофон дээр нь суучих. 5 номерын микрофоныг нээе.

Д.Энхтайван: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Гишүүн Үндэсний хөрөнгө оруулалтын банк болон Чингис Хаан банкны үйл ажиллагаатай холбоотой асуудлыг бол тодрууллаа. Эхнээс нь Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хувьд бол Эрүүл мэндийн даатгал болон Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг бол төлж барагдуулсан байгаа. Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр бол эдгээр сангуудын өр төлбөр бол одоогийн байдлаар байхгүй ээ. Хөрөнгө оруулалтын банкны хувьд бол мэдээж 2017 оноос явагдсан активын чанарын үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан. Тэгээд энэ хүрээнд бол өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хугацаатай үүрэг даалгаврыг төв банкнаас бол олгоод явж байгаа. Банкныг тогтворжуулах төлөвлөгөөг бол 2022 онд ирүүлсэн байгаад байгаа. Төв банкны хувьд бол Үндэсний хөрөнгө оруулалтын банкны тогтворжуулах төлөвлөгөөг бол тухай бүрд нь хянаад явж байгаа.

Банкны хувьд бол мэдээж нэмэлтээр гаднаас хөрөнгө оруулагч орж ирэх асуудлыг бол удаа дараа хөөцөлдсөний эцэст Төв банктай бол потенциалын хөрөнгө оруулагч нарыг бол авчирч уулзуулсан. Энэ дээр бол Төв банк, Хөрөнгө оруулалтын банк бол хамтраад ажиллаад явж байгаа.

Чингис хаан банктай холбоотой асуудал дээр бол Нийгмийн даатгалын сангийн 93,8 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн 30,9 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаад байгаа. Аль аль дээр нь бол шүүхийн шийдвэр

гүйцэтгэх ажиллагаа албадан гүйцэтгэх үйл ажиллагаа бол явж байгаа. Нийгмийн даатгалын сан дээр бол 101,8 тэрбум төгрөг олгох ёстой байснаас бол тодорхой хэмжээгээр бол үл хөдлөх хөрөнгө болон бусад хэлбэрээр барагдуулснаар одоогийн байдлаар үлдэгдэл бол 93,8 тэрбум төгрөгтэй явж байна. Тэгээд түүрүүн хэлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа бол явагдаж байгаа.

Банкны үйл ажиллагааг бол мэдээж түүрүүн хэлсэн. Бас 2017 оноос хойш активын чанарын үнэлгээгээр бол Чингис Хаан банк бас өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан. Энэ дээр бол төв банкны зүгээс өөрийн хөрөнгийг бол нэмэгдүүлэх шаардлагыг бол удаа дараа тавьж явж байгаа. Чингис хаан банк дээр бол потенциалны хөрөнгө оруулагчтай бол 2021 оны төгсгөлөөр төв банк болон банкны хувьцаа эзэмшигчидтэй бол уулзсан. 2023 оны 4 дүгээр сард төв банк дээр бол хувьцаа эзэмшигчийн хувьцааг шилжүүлэх буюу нэмэлтээр гадаад хөрөнгө оруулагч орж ирэх гэрээг бол төв банк дээр бол байгуулсан байгаа. Одоо бол хөрөнгө оруулагчдын зүгээс бид бүхэнд бол тавьж байгаа мэдээллээр бол потенциалны хөрөнгө оруулагч бол Монгол Улсад гаднаас хөрөнгөө оруулж ирэхэд бол тодорхой хэмжээний бол хүндрэл үүсээд байгаа. Энэ хүндрэлийг шийдвэрлэхэд бол эрх бүхий байгууллагуудаас бодлого, үйл ажиллагааны тусламжийг бол эрэлхийлж байгаа.

Тэгээд ер нь бол хэд хэдэн нэмэлт хөрөнгө оруулагч нарыг бол хөрөнгө оруулагчийн зүгээс бол авчирч энэ дээр бол Төв банктэй бол уулзалтуудыг хийж байгаа. Зохистой, дорвитой шийдвэр гаргахгүй байна гээд гишүүн бас хөндөж байна. Энэ дээр бол бид бүхэн мэднэ. 2019 онд Капитал банкныг бол татан буулгаж, эрх хүлээн авагч томилсон. Энэ хүрээнд одоо болтол банкны үйл ажиллагаанаас шалтгаалаад төлбөрөө

бүрэн гүйцэтгэх дарааллыг бол бүрэн барагдуулж дуусаагүй байна. Тэгэхээр бол арилжааны банкны эрх хүлээн авагчийн үйл ажиллагаа бол маш олон жилээр урт хугацаанд үргэлжилдэг. Тэгэхээр төв банк бол аль болохоор энэ түвшинд нь хүргэхгүй, наана нь шийдвэрлэх, нэмэлтээр хөрөнгө оруулагч оруулж ирж банкныг илүү хурдан хугацаанд сэргээн тогтворжуулах бодлогын үйл ажиллагааг бол баримталж байгаа. Үнэхээр хэрвээ энэ хөрөнгө оруулагч орж ирэх үйл ажиллагаа бүтэлгүйтвэл мэдээж Банкны тухай хуульд заасан нөхцөл удирдлагын дараа дараагийн арга хэмжээг шат дараалан авна.

Д.Батбаяр: Эрүүл мэндийн даатгалын газрын Бямбасүрэн дарга байна уу. Ганцэцэг дарга аа, та сууж байгаарай. Би бас танаас юм асууна. 3 номерын микрофон.

Л.Бямбасүрэн: Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын дарга Бямбасүрэн асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас тасарч, биеэ даасан ийм байгууллага болсон байгаа. Энд бол Нийгмийн даатгалын ерөнхий газраас тухайн үеийн арилжааны банканд харилцах хадгаламж хэлбэрээр байршиж байсан мөнгөн хөрөнгүүд бол хамтдаа ингэж шилжиж ирсэн байгаа. Түүрүүн Ганцэцэг дарга бас хэлсэн байгаа. Сая бас мэдээлэл өгсөн. Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байсан манай авлага бол бүрэн барагдсан байгаа. Шүүхийн шийдвэр гараад тухайн үед. Капитал банкны эрх хүлээн авагчаас бас бид нар мөнгөн хөрөнгө үлдэгдэл бол 77,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Үл хөдлөх хөрөнгийг бас авлагад тооцож хүлээж авсан хөрөнгө бол байгаа. Энэ дээр 47,2 тэрбум төгрөгийн хөрөнгө байсан. Үүний 10,5 тэрбум

төгрөгийн үл хөдлөх хөрөнгө бол борлуулагдаад, Эрүүл мэндийн даатгалын санд бол бүрэн орсон байгаа. Чингис Хаан банктай холбоотой асуудал мөн Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэр 2022 оны 6 сард гарсан байгаа. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын нэхэмжлэлийн хүрээнд авлагыг барагдуулах нь зүйтэй гэсэн Дээд шүүхийн шийдвэр бол гарчихсан. Ингээд бид нар Шийдвэр гүйцэтгэлийн газарт бол удаа дараа албан тоот хүргүүлж, энэ шийдвэрийг хэрэгжүүлээч гэсэн ийм тоотыг бол хүргүүлээд ажиллаж байгаа.

Д.Батбаяр: Цогтбаатар гишүүн тодруулга асуулт асууя.

Дав.Цогтбаатар:

Монголбанкныханд баярлалаа. Тодорхой сайхан хариулт өглөө. Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сан дээр ийм хариуцлагагүй шийдвэр гаргасан хүмүүс нь ямар хариуцлага хүлээсэн талаар л илүү дэлгэрэнгүй тодруулах гэж байсан юм. Монголбанк бүгдийг нь хариулчихлаа. Хариуцлагынх нь талаар хариуцлага хүлээж байсан хүн байна уу. Одоо энийг бол 400 орчим тэрбум төгрөг энэ тайланд тусгагдсанаар жоохон хариуцлага алдчихсан юм шиг хараад байна. Тэгээд энэ дээр ямар нэгэн хариуцлага хүлээсэн хүн байна уу гэж асуух гээд байгаа юм.

2 дугаарт нь Төрийн банкны гүйцэтгэх захирлаас одоогийн нөхцөл байдлыг бол бид нар тайлан эндээс хараад ойлгочихно. Таны өөрийн чинь юу гэдэг юм ижил түвшний банктай харьцуулахад та өөрөө ямар амбицтай очсон юм. Үр дүндээ хүрсэн юм уу. Тэр дээрээ ямар дүгнэлт хийж байгаа юм бэ л гэж асуусан юм.

Д.Батбаяр: 3 номерын микрофон дээр. Хариуцлагын асуудал дээр хариулчих. Тэгээд дараа нь Төрийн банк. Ганцэцэг дарга аа, та хариулчих. Бямбасүрэн дарга. Сая хариуцлагын

асуудал ярилаа шүү дээ. Тэгээд ямар ямар хариуцлага тавигдсан юм бэ.

Л.Бямбасүрэн: Би түрүүн хэлсэн байгаа. 2017 оны Монгол Улсын Засгийн газрын 340 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар байгуулагдахдаа Нийгмийн даатгалын ерөнхий газраас энэ өр, авлагуудыг бол шилжүүлж авсан. Тэгэхээр тэр хариуцлагатай холбоотой асуудлыг би бол хэлж мэдэхгүй байна.

Д.Батбаяр: Нийгмийн даатгалын газар Ганцэцэг дарга аа, та хариулчих. Шийдвэр гаргасан хүнд нь хариуцлага хүлээлгэсэн үү гэдэг талаар 5 номерын микрофоныг нээе.

Ц.Ганцэцэг: Тухайн үедээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэр гараад ингээд явж байсан. Манай байгууллагын хувьд бол энэ үлдсэн авлага бол барагдуулахад бас онцгой анхаарч ажиллаж байна. Өнгөрсөн оны байдлаар Чингис хаан, Капитал банктай холбоотой өр, төлбөрийг Капиталын эрх хүлээн авагчтай хамтран ажиллаад санал болгож байгаа хөрөнгүүд дээр бас ажиллаж байна. Бэлэн мөнгөөр бас мөнгө төлөгдөж байна. Тэгээд өнөөдрийн байдлаар бол Капитал банкны эхний 104,2 тэрбум төгрөгөөс 8 сарын 20-ны байдлаар 67,3 тэрбум төгрөг ний бид нар авлагатай байна. Өөрөөр хэлэх юм бол үлдсэн хэсэг нь бол барагдсан гэсэн үг. Чингис хаан банкны хувьд бол тухайн үедээ 101,7 тэрбум төгрөгийн авлагатай байсан. Үндсэндээ мөнгөөр бол барагдаж.../минут дуусав/

Д.Батбаяр: Дахиад 1 минут өгчихье. 5 номерын микрофон.

Ц.Ганцэцэг: Чингис Хаан банкны үлдэгдлийн хувьд бол 95,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Агентлагийн хувьд бол бас энэ 2 банкны хүмүүстэй хамтарч ажиллах хөрөнгө эрх хүлээн авагчаас байнга хөрөнгө санал болгож байгаа. Энэ хөрөнгийн үнэлгээ

тайлан зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг бас бид нар харгалзаж үзээд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөрөө энэ хөрөнгийг авах эсэх дээр зөвшөөрөл аваад, үндсэндээ хөрөнгийг борлуулах энэ ажлыг бол зохион байгуулж байна.

Д.Батбаяр: Гантөр дарга. Төрийн банк. 3 номерын микрофон.

Ө.Гантөр: Гишүүний асуултад хариулъя. Анх ажил авч байхад бол актив хөрөнгө маань түрүүн хэлсэн байгаа. Тийм ээ. Өнөөдрийн байдлаар өсөлт маань 57 хувьтай явж байгаа. Ажил авч байхдаа бол мэдээж ашигт ажиллагааг нь нэмэгдүүлнэ, актив хөрөнгийг нэмэгдүүлнэ гэсэн ийм зорилго тавьсан. Үүнийхээ үр дүнд бол үе шаттайгаар ингээд хүрээд явж байгаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Одоо Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Энэ оройн амрыг эрье. Тэгээд өнөөдөр бол маш чухал ийм хуралдаан болж байна. Тэгээд ажлын хэсгийнхнийг төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох яам, Тамгын газруудын бие бүрэлдэхүүнийг маш сайн цуглуулсанд бол бас Батбаяр даргыг бол үнэлж байна. Тэгээд бид нар бол энд хэн нэгний мууг үзэх гээд л ингээд л элдэв шидийн асуулт асуугаад суугаад байгаа явдал бол биш гэдгийг ойлгож байгаа байх гэж бодож байна.

Ялангуяа шинэ 30 жил гээд манай Ерөнхий сайд томьёолчхоод байгаа. Тэгэхээр энэ шинэ 30 жилдээ бид нар ер нь ямар санхүүгийн сахилга баттай явах юм бэ гэдэг энэ асуудлыг хэлэлцэж байгаа гэж бодож байгаа. Тэгээд энэ бол төрийн мөнгө гэж байхгүй, татвар төлөгчдийн мөнгө. Нэг хүүхэд гараад дэлгүүрээс чихэр авахад л НӨАТ-ын татвар төлж байгаа. Аж ахуй эрхлэгчид маань махаа идэж, үсээ зулгааж байж олсон мөнгөнөөс ямар их татвар төлж байгаа билээ. Гадаадын зээл тусламж хэчнээн их доллар, мөнгө авдаг билээ. Тэр

бүгдийгээ бид нар хэрхэн зөв зохистой зарцуулсан юм бэ гэдгийг л ер нь өнөөдөр ярилцаж байна. Тэгээд энэ маш их асуудлууд байна. Маш их. Одоо бид нар бол бүгд мэргэжлийн санхүүгийн хүмүүс биш. Гэхдээ зүгээр ингээд л уншихад бол ерөөсөө энэ чинь юу вэ, яав аа, ийв ээ л гэмээр ийм асуудлууд байна. Тэгээд яг мэргэжлийн санхүүчид унших юм бол бүр аймаар санагдах байх гэж би бол үнэндээ бодож байна. Ингээд 5 асуулт байна.

1 дүгээрт энэ нийт 9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй гэж байх юм. Тэгэхээр энэ хэр ноцтой зөрчил юм бэ. Тэгээд энэ дотор нөгөө манай хүнд зориулсан яам гээд би бас жоохон шүүмжлэлтэй ханддаг. Олимпын яам гэх юм уу, төсвийн ерөнхийлөн захирагч асанд бол 2,7 тэрбум төгрөг гэж байсан байх юм.

Дахиад баталсан, төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан 13,9 тэрбум төгрөг гэж байх юм. Энэ үр ашиггүй зарцуулсан гэхээр яг юунд зарцуулсан гэсэн үг вэ. Зориулалт бусаар, тэгээд үр ашиггүй гэхээр яг юу юунд зарцуулчихсан юм бол.

3-д нь анхан шатын баримтгүй, бүрдүүлэлт дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн. 256,3 тэрбум төгрөг. Би бол ерөөсөө энийг ойлгохгүй байна. Энэ үндсэндээ ямар ч анхан шатын баримтгүйгээр худалдан авалт хийчихсэн юм уу, ажил, үйлчилгээ авчихсан юм уу. Тэгээд мөнгийг нь гаргачихсан, төлчихсөн гэсэн үг гэж би ойлгож байна. Тэгэхээр ийм юм байж болдог юм болов уу. Бүр гайхаж байна. Тэгэхээр энэ чинь юун дээр үндэслэж тэр ажил үйлчилгээг авсан, тэр мөнгийг төлсөн гэж бодож байгаа юм бол.

4 дүгээр асуулт. Бид нар бол гадаадын зээл, тусламжийг маш их ашиглаж байгаа. Энд нэг жишээ байна л даа. 26,8 хувь нь энэ төсөл, арга

хэмжээнүүдийн тусламжаар гэж байгаа юм. 73,2 хувь нь зээлээр гэж байгаа юм. Гадаадын шүү дээ. Гэтэл төсвийн ерөнхийлөн захирагч нар нь хүрсэн үр дүн, түүнийхээ танилцуулгыг ирүүлдэггүй гэж байгаа юм. Сангийн яаманд.

Д.Батбаяр: Дахиад нэг минут өгье.

Ж.Баярмаа: Яагаад Сангийн яаманд ирүүлдэггүй юм бол. Төсөв төсвийн ерөнхийлөн захирагч нар маань энэ гадаадаас авсан зээл, тусламжаа хэрхэн зарцуулж байгаа талаараа яагаад тайлагнадаггүй юм бол. Энэ чинь цаагуураа нөгөө авлигын индексэд нөлөөлөөд явж байдаг байхгүй юу. Авлигын индексэд маш их юм нөлөөлдөг юм шүү дээ. Тэрний 1 бол энэ.

Сүүлийн асуулт. Энэ нөгөө улсын төсөв, орон нутгийн төсөв 12 төслийн тоо гэж байна. Энэ нөгөө би концессын гэрээний талаар асуух гэж байна л даа. Барих, шилжүүлэх төрлийн концесс гээд. Тэгээд энэ дээр жишээлбэл 2023 оны эргэн төлөлт 251 тэрбум төгрөг төлсөн байна. Эцсийн үлдэгдэл 230 тэрбум тэр төгрөг гээд. Нийт 463 тэрбум. Тэгэхээр энэ барих, шилжүүлэх төрлийн концесс гэдэг нь ямар төслүүд ингээд гарч яваад байна вэ. Энэ 12 төсөл гэдэг нь ямар төсөл вэ. Тэгээд энэ ямар хугацаатай ингэж баригдаад, ямар хугацаанд энэ их мөнгө буцаж гараад байдаг юм бэ. Нөгөө барих ВОТ буюу барих ашиглах шилжүүлэх гэдэг энэ концессын төрөл ер нь.../минут дуусав/

Д.Батбаяр: Аудитын дүгнэлттэй холбоотой асуулт хэн хариулах вэ. 6 юу 7 юу. Дугаараа өргөчих. 7 номерын микрофон.

Я.Самбууням: Үндэсний аудитын газар Самбууням байна. Баярмаа гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн тайланд та 3 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тайлагнаагүй гэж 9 тэрбум гээд андуурчхав уу, өөр юуг хэлчхэв үү.

Засгийн газрын санхүүгийн тайланд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Төрийн санд байрилах барьцаа хөрөнгийн дансны 13 дансны үлдэгдэл 3 тэрбум төгрөгийг Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тайлагнаагүй ийм зөрчил илэрсэн. Тэгээд энэ зөрчлийг бол арилгуулж, тайлагнуулсан байгаа юм. Энийг аудитаар илрүүлж, зөрчил болгож авсан байгаа.

Батлагдсан төсвийн 13,9 тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулсан гэдэг дээр нь нөгөө анхны батлагдсан төсвийнх нь хүрээнд нь биш, зориулалт бусаар зарцуулсныг нь бид бас энэ илрүүлэлт болгож гаргаж ирээд, аудитаа илрүүлээд байгаа юм. Анхан шатын баримтын бүрдэлгүй гэдэг бүр нөгөө жижиг төсвийн ерөнхийлөн захирагчдаас нь авхуулаад ингээд үзэхээр зэрэг бол анхан шатын баримт, худалдан авалтын баримтууд нь нөгөө и-баримтаар нотлогдохгүй. Энэ зарцуулалт нь бол бас нөгөө анхан шатын баримтын бүрдэл хангагдахгүй, гэрээ хэлэлцэлгүй, и-баримтгүй ийм зөрчлүүдийг нэгтгээд явахаар зэрэг бол ийм 256,3 тэрбум төгрөгийн зөрчил болж гарч ирж байгаа юм.

Д.Батбаяр: Сангийн яам. Дараагийн хариу асуултад хариулах уу. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Тэр концессын тухай асуултыг Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариулчих уу. Эдийн засаг, хөгжлийн яам хариуцдаг юм шүү. Энэ гүйцэтгэлийн аудитын тайлан дээр Сангийн яам гадаад зээлийн тайлан ирүүлдэггүй гэж тийм юм байгаа юм уу. Үгүй ээ, би тэрийг ёстой сайн ойлгосонгүй. Баярмаа гишүүний буруу гэж юу байх вэ. Тэр дээр тэгж байгаа бол. Аудитынхаа тэрийг нэг тайлбарлаад өгөөч. Ямар асуудал юм бол. Байнга л авдаг, байнга л хүргүүлдэг. Ганц манайх ч биш Эдийн засаг, хөгжлийн яам, ер нь төсвийн ерөнхийлөн

захирагч нар энэ тайлангаа ер нь бүгд л цаг хугацаанд нь л хүргүүлдэг дээ. Аудитынхан л хариулчихмаар байна.

Тэр концесс дээр Эдийн засаг, хөгжлийн яамныхан нэмж хариулаарай. Танай хариуцдаг ажил шүү.

Ер нь ийм байгаа. Хуучин одоо нөгөө хүчингүй болчихсон Концессын хууль дээр барих, шилжүүлэх гэдэг аюултай тийм концессын төрөл байсан юм. Ингээд энэ 2017 оны Улсын Их Хурлын тогтоолоор, захирамжаар энэ хэдийгээр хууль нь байсан боловч Засгийн газарт үүрэг өгөөд, дахиж барих, шилжүүлэх энэ төрлөөр концесс гэрээ хийж огт болохгүй шүү. Үүнийгээ зогсоо гээд үүрэг өгсөн байгаа. Тэрнээс хойш бол барих, шилжүүлэх нэг ч шинэ концесс бол хийгдээгүй. Одоо Концессын хууль маань ч өөрөө хүчингүй болсон. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль гээд шинэ хуулийн зохицуулалттай болж ирсэн байгаа. Харин 2017 он хүртэл хийгдсэн 11 билүү, 12 ийм концессын шууд барих, шилжүүлэх төрлийн концесс хийгдээд, тэндээс хэд хэдэн төслүүдэд нь дуусаад тухайн үедээ шууд төрд шилжүүлээд өгчихсөн. Ингээд гэрээгээр цувуулаад төлбөрүүдээ аваад явж байгаа ийм зүйлүүд байгаа. Тэр талаар Эдийн засаг, хөгжлийн яам нэмж хариулаарай.

Д.Батбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөлөл байвал та 3 номер дээр очоод суучих. Хэн хариулах вэ. Микрофон дээр очоод хэлээд, дараа нь цаасаар. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Энэ ингэсэн юм байна шүү дээ. 3.1.82 дээр гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ барилга байгууламжийн санхүүжилтийг 26,8 хувийг тусламжаар, 73 хувийг нь зээлээр санхүүжүүлсэн бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нар хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж Сангийн яаманд ирүүлээгүй гэхсэн юм байна. Тэгвэл энийг Аудитынх яг хэн хэн гэдэг

төсвийн ерөнхийлөн захирагч нар юм байна. Тэрийг нь тодорхой болгоод, төсвийн ерөнхийлөн захирагч нар энэ дээр нэг хариулаадах уу. Манайх бол тайлангуудаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд байнга ирүүлдэг юм.

Д.Батбаяр: Тэгвэл аудитын байгууллага. 7 номерын микрофон.

Я.Самбууням: Манай төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 3.1.81 дээр байгаа. 82 дээр гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн 26,8 хувийг тусламжаар, 73,2 хувийг зээлээр санхүүжүүлсэн бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нар хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж Сангийн яаманд ирүүлээгүй байна гэж зөрчил болгож тайлагнасан байгаа. Тэгээд энэ дээр бол ерөөсөө гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсвийн ерөнхийлөн захирагчид ганц нь ч тайлангаа ирүүлээгүй байгаа.

Д.Батбаяр: Баярмаа гишүүний тодруулга.

Ж.Баярмаа: Яах вэ, энэ яг төсвийн ерөнхийлөн захирагч нар л хариулах ёстой асуулт л даа. Уг нь. Яагаад ирүүлдэггүй юм бэ. Авах болохоороо уургын морь шиг авчхаад, тэгээд өгөх болохоороо ургаа хад шиг ингээд зогсчихдог гэсэн үг. Энэ яах вэ зөв. Яагаад гэхээр өөр тайланд бас байгаа. Трансперенси интернэйшнл нөгөө авлигын индексээр яагаад Монгол улс ухраад байгаа вэ гэдэг дээр маш тодорхой биччихсэн байгаад байгаа юм. Яг энийг гадаадын зээл тусламж авчхаад, яг авсан тэр гэрээнийхээ нөхцөлд болохоор удаа дараа ингэж тодорхой хугацаанд ингэж, тэгж тайлагнана гэж гэрээ байгуулж, нөхцөл үүсгэсэн хэр нь ерөөсөө тайлагнадаггүй гээд. Тэгээд энэ чинь өөрөө яам гэлтгүй энэ чинь ерөөсөө төсөв ерөнхийлөн

захирагч нар бүгд л юм шиг байгаа юм шүү дээ. Тэгээд үгүй ээ, одоо бүх сайдууд гэсэн үг шүү дээ. Төсөв ерөнхийлөн захирагч гэдэг чинь. Тэгэхээр Сангийн яам болохоор авдаг гээд байна тээ. Ирүүлдэг гээд байна. Тэгэхээр нөгөөдүүл нь болохоор ирүүлээгүй байна гээд ингээд заачихсан. Энэ бол ирүүлдэггүй нь л үнэн байх. Яагаад гэвэл тэр Трансперенси интернэйшнлийн тайлантай яг энэ өгүүлбэр давхцаж байгаа юм л даа. Тэгээд ирүүлж байгаач ээ. Энэ чинь нөгөө зээлжих зэрэглэл, нөгөө гадаадын.../минут дуусав/

Д.Батбаяр: Одоо би асууна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна уу. Ганбат дарга. 1 ийм асуулт байна. 2023 оны 7 сарын 7-нд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Пүрэвдоржоос албан бичиг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд очсон байна. Энэ 2022 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор сөрөг болон хязгаарлалттай дүгнэлт авсан зарим байгууллагуудад арга хэмжээ, зарим албан тушаалтнуудад арга хэмжээ аваад, 2023 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулна уу гэсэн утгатай албан бичиг очиж байжээ. Тэгээд энэ албан бичгийн хүрээнд ямар арга хэмжээ авсан бэ. Яагаад дэд хороонд танилцуулаагүй вэ гэсэн ийм асуулт байна. 5 номерын микрофоныг нээе.

Б.Ганбат: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Ганбат. Гишүүний асуултад хариулъя. 2023 оны 7 сарын 7-нд Зарлагын дэд хорооноос Монгол Улсын Ерөнхий сайдын нэр дээр албан бичиг ирсэн. Энэ албан бичиг бол агуулгын хувьд өмнөх жилийн буюу жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээр сөрөг буюу хязгаарлалттай дүгнэлт авсан ийм төсөв захирагч нарт, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож мэдэгд гэдэг ийм агуулгаар. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу

Үндэсний аудитын газар бол саяын хуульд заасан эрхийнхээ хүрээнд бол хариуцлага тооцоод авах бүрэн эрх нь бол байгаа. Үндэсний аудитын газраас энэ хариуцлага тооцох асуудлын хүрээнд 2 чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр 1 дүгээрт санхүүгийн хариуцлага буюу тэр тухайн зөрчилтэй холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг эргүүлэн татах, буцаах, буцаан төлүүлэх ийм арга хэмжээ явагдаж байгаа. Энэ нь бол Үндэсний аудитын газраас төлбөрийн акт нь тавигдаад, тодорхой хугацаатай, тодорхой албан тушаалтанд даалгаад, ингээд төлбөрийн акт баталгаажигдаад, үүний хэрэгжилт нь эргэж Үндэсний аудитын газарт тайлагнагдаад ингээд явж байгаа.

2 дахь чиглэлийн хариуцлагын чиглэлийн асуудал нь бол тухайн гаргасан зөрчилтэй үйл ажиллагаа хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаатай холбогдуулаад өгч байгаа албан шаардлага, зөвлөмжийн хүрээнд бусад хууль тогтоомжоор тухайлбал Төрийн албаны тухай хууль тогтоомжоор томилох эрх бүхий, хариуцлага тооцох эрх бүхий албан тушаалтанд тодорхой чиглэл өгч ингэж Үндэсний аудитын газраас өгч байгаа. Энэ хүрээнд бол тухайн төсвийн шууд төвлөрүүлэн, ерөнхийлөн захирагч нар бол холбогдох хариуцлагынхаа арга хэмжээг аваад, эргэж мэдэгдэх ийм үүрэгтэй. Энэ асуудлын хүрээнд бол манай төсвийн шууд төвлөрүүлэн, шууд захирагчдын хувьд бол энэ гүйцэтгэлийн хувьд бол хэрэгжилт нь хангалтгүй байх ийм асуудал бол байгаа. Энэ асуудал дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бол бид нар Үндэсний аудитын газрынхаа тухайн жилийн жилийн эцсийн байдлаар гаргасан энэ аудитын дүгнэлт, зөвлөмж, шаардлага энэ асуудлын хүрээнд хязгаарлалттай буюу сөрөг, зөрчилтэй гэсэн ийм аудитын дүгнэлт авсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг нэгтгэж, улсын хэмжээнд нэгтгэж.../минут дуусав/

Д.Батбаяр: Би тодруулга асуулт асуучихъя. Тэгээд би 2 дахь асуулт нь болохоор хэрвээ арга хэмжээ авсан бол 2023 оны 9 сарын 1-нд Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулаагүй вэ гэдэг асуулт асуусан байгаа. Тэгээд Ерөнхий сайд маань энэ төсвийн сахилга бат, авлигын эсрэг төсвийн сахилга батыг бэхжүүлэхийн төлөө манлайлж оролцох ёстой хүн. Бүх эрх мэдэл нь өөрт нь байгаад байгаа учраас. Тэгэхээр энэ Үндэсний Үндэсний аудитын газрын дүгнэлтэд үндэслээд сөрөг болон хязгаарлалттай дүгнэлт авсан энэ төрийн байгууллагуудын зохих, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага ноогдуулсан байх гэж бодож байгаа. Тэгэхээр яг нэг бүрчлэн дэлгэрэнгүй энэ ажлыг яагаад тайлагнаагүй вэ гэдэг асуулт байна.

Б.Ганбат: Энэ дээр ер нь Үндэсний аудитын газрын тэгээд дээр нь тухайн үеийн Төсвийн зарлагын дэд хорооны даргын албан бичгийн хүрээнд улсын хэмжээнд яг энэ сөрөг буюу хязгаарлалттай дүгнэлт авсан аж ахуйн нэгж, байгууллагын бүх хариуцлага тооцсонтой холбогдолтой үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэж байгаа. Нэгтгэгдээд бэлэн болсон байгаа. Албан бичиг дурдсанаар бол 2023 оны 9 сарын 1-ний дотор гэгчихсэн ийм хугацаа заасан ийм албан бичиг байгаа. Тэгээд одоо бид нар нэгтгэлийнхээ гүйцэтгэлийг тооцоод, албан ёсоор одоогийн Төсвийн зарлагын дэд хороонд бол хүргүүлье.

Д.Батбаяр: Хэзээ.

Б.Ганбат: Өнөөдөр 29-ний өдөр. Тэгээд одоо ирэх 7 хоног 9 сарын 1-ний өдөр чинь амралтын өдөр болчихоод байгаа юм л даа бас.

Д.Батбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон

“Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Заяабал гишүүнээр тасалъя. Булгантуяа гишүүний микрофоныг нээе.

Х.Булгантуяа: Гүйцэтгэл дээр ганцхан Сангийн сайд биш уг нь бусад сайд нар ч гэсэн суумаар байгаа юм. Манай төрийн байгууллагынхан зүгээр нэг гүйцэтгэлээ хамгаалаад өнгөрөх биш, дахиж алдаа дутагдал гарахгүй байх дээр бид яах ёстой вэ гэдэг дээр уг нь та бүхэн маань саналаа хэлбэл илүү зүгээр байсан юм. Сая ер нь энэ 2023 оны төсвийн гүйцэтгэлийг ярьж байхад Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн үлдэгдлийн асуудлыг маш их ярилаа. Би энэ дээр тоонуудыг нь хэлээд өгчихье гэж бодлоо. Чингис хаан банк дээр 2012 оноос авхуулаад жишээлбэл анх мөнгө байршуулж эхэлсэн. 13 тэрбум төгрөгийг анх байршуулаад 2016 хамгийн сүүлд ингээд 125,8 тэрбум төгрөг хүртэл байршуулсан байна. Үүнээс бол 43 орчим тэрбум төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангийн сангийн мөнгө байсан. Капитал банканд хэдийгээр 2007 онд гэрээ байгуулсан ч гэсэн тэр үед 5,2 тэрбум төгрөг л байршуулсан байсан. Түүнээс хойш мөнгө байршуулахгүй байж байгаад 2011 онд 24,7, 2012 оноос 31,4 тэрбум төгрөг, сүүлдээ 2016 онд 224 тэрбум төгрөг хүртэл байршуулсан. Ингээд энэ хугацаанд энэ банк дээр жишээлбэл байршуулаад банкнуудын активын чанар муу байна гэдгийг үнэнийг хэлэхэд Монголбанк бас илрүүлж чадаагүйгээс болоод ишмтгэл төлөгчдийн мөнгө эрсдэлд орсон. Дараа нь бид нар Валютын сангийн хөтөлбөрт ороод, банкнууд дээр активын чанарын үнэлгээ хийхэд эдгээр банкнууд бол хүндэрсэн байсан нь мэдэгдэж, нөхцөл байдал бол хүндэрсэн.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, энэ үндэсний зөвлөлүүд дээр бол салбар салбарын төлөөлөл байгаа.

Жижиг, дунд бизнес эрхлэгч ч байгаа. Үйлдвэрчний эвлэл ч байгаа. Эдгээр хүмүүс бол банкнуудын активын чанар ямар байна вэ гэдэг талаар нарийн мэдээлэл бол үнэндээ байхгүй. Тийм учраас эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд сая Нийгмийн даатгалын хууль дээр жишээлбэл бид нар системийн хэмжээний том банкнуудад байршуулна. Монголбанкнаас энэ дээр бүр бид нар зөвлөмж авна гэдэг ийм зүйлүүдийг хуульд нь оруулж өгсөн. Өөрөөр хэлбэл ийм жижиг бөгөөд эрсдэлтэй банк дээр дахиж байршуулахгүй.

Энэ дээр ахиад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөнгө ч гэсэндээ бас авлага бас байгаа. Тэгэхээр тэр бол уже бас дурдагдаагүй байна. Тэгэхээр та бүхэн маань одоо харин бид нарын санаа зовох зүйлийн асуудлууд нь сая Нийгмийн даатгалаас ч, Эрүүл мэндийн даатгалаас ч нэг нь асуугаад нөгөөдөх нь хариулаад өнгөрөх биш. Одоо та нар дээр үүсээд байгаа нөхцөл байдлаа ярих ёстой байхгүй юу. Одоо бид нар баахан хэрэгтэй, хэрэггүй үл хөдлөх хураагаад авчихсан. Эрх хүлээн авагчаас. Тэгээд манай энэ төрийн захиргааны хэдэн албан хаагчид үл хөдлөх хөрөнгийн менежментийн ажлыг хийгээд суугаад байгаа юм. Түрээслэх гээд л, зарах гээд зарж чадахгүй. Одоо бүр аргаа бараад Ремакс гэдэг компанийг гуйгаад, манай юмыг зараад өгөөч гээд. Тэндээс нь олигтой зарчихаар юм бас байхгүй юм шиг байгаа юм. Гахайны ферм юу юу ч гэнэ вэ. Одоо сүүлдээ бүр юу ч хамаагүй шахаад байдаг болсон. Одоо үлдсэн юмнууд нь энэ. Энийг л авахгүй бол хэцүүднэ шүү гээд ингээд ийм юм яриад байдаг. Тэгэхээр дэд хорооны дарга аа, одоо нэгэнт үүнийг мэдээж авлагын талаар араас нь хөөцөлдөх ёстой. Тэгэхдээ энэ олон активуудыг бид нар зарж борлуулах ажлыг төрийн захиргааны хэдэн албан хаагчид үүнийг хийж чадахгүй. Активын удирдлагын хуультай больё. Ингээд энд байгаа активуудыг хурдан эргэлтэд оруулахгүй бол одоо Нийгмийн даатгалын ерөнхий

газрын хэдэн албан хаагчид үүнийг зарж борлуулах гээд явж байх юм бол энэ олон үл хөдлөхүүд удахгүй шамишдаад, үргүй болоод дуусна.

Дээрээс нь энэ олон байгууллага болгон дотроо дотоод аудитын бүтэцтэй байгаа. Тэр хүмүүс бас юу хийж байв гэдэг асуудлууд бас үүснэ. Дотоод аудитын тухай хуультай больё гэж бид нар яриад маш удаж байна. Энэ хууль хаана байна вэ гэдэг. Яагаад гэвэл нэгэнт даргатай, бүтэцтэй ийм байгаа юм бол тэр хүмүүс тэгвэл бас хариуцлага хүлээх ёстой. Тэр хүмүүсийн бид нар бас ажиллах нөхцөлийг нь эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх ёстой. Үүнийг бид нар бас өөрийн эрхгүй ярих ёстой.

Нөгөө талдаа улсын төсөв, орон нутгийн төсвөөр ийм олон хөрөнгүүд бас баригдаж байна. Эд нарын бүртгэлүүд салбарын яамнууд дээрээ, төсвийн ерөнхийлөн захирагч дээрээ ерөнхийдөө тавигдаад явж байгаа ч гэсэн бид нар энэ их улсын бүртгэлүүдийг үл хөдлөх хөрөнгүүдийн барилга байгууламжуудын бүртгэлүүдийг сайжруулах ажлыг ер нь их сайн хийх ёстой юм байна лээ.

Д.Батбаяр: Заяабал гишүүний микрофоныг нээе.

Б.Заяабал: Тэгэхээр та бүхэн мэдэж байгаа. Саяхан Зас Засгийн газар, Улсын Их Хурал Засгийн газрын өргөн барьсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр гээд 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байгаа. 590 орчим арга хэмжээ төлөвлөгдөж батлагдсан. Тэгэхээр манай яг төрд ажиллаж байгаа манай яг энэ арга хэмжээнүүдийг хэрэгжилтийг нь хангаж ажиллах ёстой та бүхний хувьд ямархуу хэмжээний их ажил энэ 4 жил байна вэ гэдэг нь эндээс бол харагдаж байгаа юм. 2020-2024 оны хугацаанд бол Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр 250 орчим арга хэмжээ байсан. Одоо тэр нь

2,5 дахин бараг ингээд өсчихсөн. Ийм хэмжээний их ажлыг бид нар энэ 4 жилд хийж гүйцэтгэх болж байгаа гэдгийг та бүхэн бас мэдэж байгаа байх. Энэ 4 жилийн хөтөлбөр дээр үндэслээд жил болгоны улсын хөгжлийн төлөвлөгөө гэж бас гаргадаг. Ингээд 590 арга хэмжээгээ бид нар 4 жилд хуваагаад үзэх юм бол бараг жилдээ 150 орчим арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр байгаа. Өнөөдөр сая 2023 оны төсвийн гүйцэтгэлийг бид нар ярьж байна. Үндсэндээ 123 арга хэмжээний тухай л бид нар яриад л ингээд л дууслаа шүү дээ. Хэрэгжилтийн хэдэн хувьтай энэ тэрээ гээд ингээд яриад дуусаж байна. Тэгэхээр цааш цаашидаа бол бид нар хэрэгжилтийг нь төрийн бодлогын баримт бичиг дээр тусгачихсан бодлогууд, үйл ажиллагаануудыг бүрэн хэрэгжүүлэх дээр манай холбогдох төрийн албан хаагчид маань бас онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна. Энийгээ бол жил жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийн тулд бас бид нар энэ төсөв дээрээ бас энийг бол уялдаатай энэ бодлогын арга хэмжээнүүдийгээ уялдаатай авч үздэг. 2011 оноос бол манай Монгол Улсын төсөв бол тухайн төсвийг хөтөлбөр, арга хэмжээ дээр суурилж байж төсвийг боловсруулдаг ийм шинэ тогтолцоонд бид нар шилжээд, даруй 10 жил өнгөрөөд явж байна. Өмнө нь бол бид нар норм норматив дээр тулгуурласан ийм төсвийг боловсруулж явдаг байсан. Ингээд сүүлийн 10-аад жил бид нар энэ төсвийн хөтөлбөр арга хэмжээ дээр зүгээр суурилсан. Тэрийгээ биелүүлэхийн төлөө бид нар энэ жилийн төсвийг боловсруулж явдаг. Харамсалтай нь ингээд 2023 оны саяын төсвийн төлөвлөгөөнүүдийг гүйцэтгэлийг аваад үзсэн ч гэсэн энэ жилийн төсвийн хөтөлбөр арга хэмжээнд хүрсэн үр дүн гэдэг дээрээ бол туйлын хангалтгүй байна. Та бүхний аудитаар ирүүлсэн материалуудыг аваад үзэхэд бол үндсэндээ тавьсан зорилт арга хэмжээ хангасан, 100 хувь биелсэн гэсэн ийм тавьчихсан боловч бодитоороо тэр арга

хэмжээ нь яг тийм байгаа юу гэвэл үгүй шүү дээ. Боловсролын сайд Наранбаяр байсан. Жишээлбэл сая энэ сургууль завсардалтын түвшинг буулгаж байхгүй болгоно гэдэг ийм зорилт жишээлбэл байлаа гэж бодоход үндсэндээ суурь үзүүлэлт нь гээд 90 хувь тавьчихсан. Тэрийгээ 95 хувь болгоно гээд тавьчихсан. Тэгээд тухайн жилийн хугацаанд хүүхдийн сургууль завсардалттай холбоотой яг юу хийсэн юм бэ. Ямар ажил хийгээд 5 хувь нэмэгдсэн юм бэ. Тэр нь төсөв дээр ямар дэмжлэгүүд нь байгаа юм бэ гэдэг дээр ямар ч тодорхойгүй. Ийм зорилтот түвшин хөтөлбөр арга хэмжээ дээр бас ингэж оруулж ирдэг ийм явдлуудыгаа цааш цаашидаа бас та бүхэн бас анхаараарай гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Тэгээд энэ дээр бол зайлиггүй тийм 90, 80 гэсэн өндөр хувь байх шаардлагагүй шүү дээ. Үнэндээ бодит түвшин 30 хувь байгаа бол 30 хувиа тавиад тэрийгээ яаж 1 хувиар ч гэсэн нэмэгдүүлэхийн төлөө бүгдээрээ яаж ажиллах юм гэдэг дээр Улсын Их Хурал бид нар бас юу анхаарах юм гэдэг дээрээ бүгдээрээ хамтраад Монгол Улсын хөгжлийн төлөө хамтарч ажиллах зайлиггүй шаардлага байна. Аудитын байгууллага ч гэсэн цааш цаашидаа төсвийн жилийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэхдээ яг ийм бодит чанарын үзүүлэлт дээр бид нар онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна. Тэгж байж бид нар бодит үр дүндээ хүрнэ шүү дээ. Тэгэхгүй бид нар нэг нэгнийгээ хуураад 90 хувийн зорилт суурь түвшинтэй 95 хувь хүргэнэ гэххэд ямар ч ажил хийгээгүй байж 95 хувь хүргэсэн мэтээр худлаа тайлан гаргадаг ийм явдлыг цаашидаа гаргамааргүй байна. Ингээд цаашидаа бол миний санааг хэлсний дагуу энэ гүйцэтгэлийн тайлан дээр бүгдээрээ чанарын үзүүлэлтийг гаргаж дараа, дараа жилийн зорилт, арга хэмжээ, төсөв дээрээ яг юун дээрээ анхаарах вэ, жилийн дараа ямар үзүүлэлтэд хүрэх вэ гэдэг дээрээ

бүгдээрээ их онцгой анхаарч ажиллах ийм шаардлагатай байна гэдгийг хэлье. Ингээд цааш цаашдаа бид нар энэ дээр би онцгой анхаарч ажиллана.

Д.Батбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлж дууслаа.

Одоо “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт дууслаа. 9 гишүүн санал хураалтад орсноос 6 гишүүн дэмжиж, 66,7 хувиар тогтоолын төслийг дэмжлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн миний бие чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

“Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тэгээд Зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа. Мөн ажлын хэсэгт хуралдаанд хүрэлцэн ирж оролцсон ажлын хэсгийнхнээ бүгдэд нь баярлалаа. Амжилт хүсье.

19.30 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ